



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ШААРДЛАГАТАЙ
БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2020 он

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор **С.Оюунгэрэл**

Утас: 263755 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитын менежер **Б.Саруул**

Утас: 261805 Цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор **Б.Батдэлгэр**

Утас: 261675 Цахим хаяг: batdelgerb@audit.gov.mn

Аудитор **Б.Хаш-Эрдэнэ**

Утас: 261675 Цахим хаяг: khasherdeneb@audit.gov.mn

Аудитор **Б.Булган**

Утас: 261675 Цахим хаяг: bulganb@audit.gov.mn

Аудитор **М.Гүнжмаа**

Утас: 261675 Цахим хаяг: gunjmaam@audit.gov.mn

Аудитор **Э.Бүгүнүтэй**

Утас: 261675 Цахим хаяг: bugunuteie@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

┐Аудитын тайланг баталгаажуулах тухай┐

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Төсвийн байнгын хороонд тус тус хүргүүлэхийг Стратеги удирдлагын газар /Б.Бундхорол/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т тус тус даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилт үр дүнг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /У.Хүрэлсүх/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дарга /С.Чинзориг/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга /Д.Зоригт/-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг УИХ-ын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэхэд бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч /О.Тэнгис/-т даалгасугай.

5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Батдэлгэр/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	3
Графикийн жагсаалт.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Аудитын хязгаарлалт:	6
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7

БҮЛЭГ 1. БИЕ ДААСАН БАЙХ ЗАРЧИМД СУУРИЛСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

*Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс сангийн бие даасан байх болон сангаас даатгуулагч шударгаар үйлчилгээ авах зарчмууд алдагдаж байна.....*9

*Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан журмын даатгалын хэлбэрээр нийгмийн даатгалын тогтолцоонд бүрэн хамруулах шаардлагатай байна.....*9

Нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийхгүйгээр зардлыг санхүүжүүлсэн байна.10

*Шимтгэлд суурилсан тэтгэврийн даатгалын тогтолцоонд шилжсэнээс хойш тэтгэвэр тогтоолгосон иргэний 1995 оноос өмнөх хугацаанд ажилласан жилд ногдох тэтгэврийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр тодорхойгүй, сангаас санхүүжүүлж байгаа нь санг алдагдалд оруулах суурь шалтгаан болсон байна*11

*Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөгөөр санд 37.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 704.6 тэрбум төгрөгийн зарлага гарсан нь тэтгэврийн даатгалын санг алдагдалд оруулахад нөлөөлсөн байна.....*12

*Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлал үүсгэж мөнгөжүүлэх асуудал эрх зүйн зохицуулалтгүй байна.....*12

*Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмсэн шийдвэр нь ажил олгогч, даатгуулагчийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдахгүй байна*13

*Нас барсан иргэдийн төлсөн шимтгэлийг хэрхэх талаар эрх зүйн зохицуулалтгүйгээс даатгуулагч хохирох эрсдэл үүссэн байна*14

*Төрийн байгууллага хооронд мэдээлэл шуурхай солилцох программ хангамжийн дутагдалтай байдлаас шалтгаалж нас барсан хүнд илүү тэтгэвэр олгох нөхцөл бүрдсэн байна*15

*Нас барсан иргэний дараагийн сарын тэтгэврийг олгоогүй зөрчил илэрсэн байна*15

*Засгийн газар тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, гаргасан шийдвэрийн үр нөлөөг бүрэн хариуцахгүй байгаа нь сангийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн байна*16

*Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс өндөр цалин авч байгаа даатгуулагчийн ажил олгогчоос төлж байгаа шимтгэлийн дүн тэтгэвэр тогтоолгоход нөлөөлөх эрх зүйн зохицуулалтгүй байна.....*17

*Нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчид илүү төлсөн шимтгэлээ буцаан авах талаар мэдээлэл өгөөгүй, эрх зүйн зохицуулалтад мэдээлэл өгөх асуудал тусаагүй зэргээс шимтгэлээ илүү төлсөн даатгуулагчийн 90.2-99.3 хувь буцаан олголтгоо аваагүй байна*18

*Тэтгэврийг хууль, журмын дагуу тогтоохгүй байгаа суурь шалтгааныг арилгаагүйгээс тэтгэврийг илүү болон дутуу тогтоох асуудал жил бүр давтагдан гарсаар байна*18

*Тэтгэмжийн даатгалын сангаас санхүүжүүлэх жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн төсвийн төлөвлөлтийг боловсруулах аргачлалыг сайжруулах шаардлагатай байна*19

*Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хууль тогтоомжид нийцүүлэн олгоогүй байна*19

*Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл жил бүр дунджаар 20.7 хувийн өсөлттэй байна*20



Үйлдвэрлэлийн осолд өртсөн даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг сэргээх, сэргээн засах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.....	20
Ажилгүйдлийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг нэмэгдүүлж байгаа хэмжээ 2012 оноос 4.8 дахин буурсан байна	22
Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгож байгаа сургалтын тогтолцоо үр нөлөөгүй байна.....	23
Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт төлөвлөснөөс хэтрээгүй байна.....	23
Эрүүл мэндийн даатгалын сангаас үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо болон зардлын хэмжээ тогтмол өсөлттэй байна.....	24
Эрүүл мэндийн даатгалын сангийн эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан нь даатгалын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог алдагдуулж болзошгүй байна	25
Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны талаарх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна	25
Эрүүл мэндийн нийт зардалд хувь хүний төлөх төлбөрийн эзлэх хэмжээ буураагүй байна.....	26
Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын тодорхой хувийг хариуцах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 2014 оноос хойш шинэчлэн батлаагүйгээс иргэн өөрөөсөө төлж байгаа зардал өсөхөд нөлөөлсөн байна	26
Хуулийн дагуу байгуулах эрсдэлийн нөөцийн санг байгуулаагүй байна	27
Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлаа гэр бүлийн өөр нэг гишүүнд шилжүүлэх хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байна	27
Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг үр ашигтай удирдах эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.....	27
Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн хүүгээс олох боломжит орлого болох 4.9 тэрбум төгрөгийг тэтгэврийн зээлийн хүүг бууруулахад зарцуулсан байна.....	29
БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРХ ЗҮЙН ОРЧИН ЗӨРЧИГДӨЖ, ҮР ДҮНГҮЙ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.....	32
Төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс төсөвт өртөг нэмэгдэж, хэрэгжилт удааширсан байна	32
Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад үндэслээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, үр ашиггүй зардал гаргасан байна	33
Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох “Үнэлгээний хороо”-г байгуулахдаа ил тод байдлыг хангах зарчмыг баримтлаагүй байна	34
Нийгмийн даатгалын байгууллага ажилтнуудад мөнгөн тэтгэлэг олгосны дараа журмын шаардлагаа зөрчсөн, нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж байгаагүй хүмүүст орон сууцны мөнгөн тэтгэлэг олгосон байна	34
Сангуудад он дамжсан найдваргүй авлага үүссэн байна	35
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нэмэгдэж, даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авч чадахгүй байх эрсдэл үүсэж байна.....	37
Нийгмийн даатгалын ерөнхий газар хяналт, шалгалтыг тогтмол хийдэг боловч жил бүр зөрчил давтагдан гарч байгаа нь хяналт, шалгалт үр нөлөө багатай байгааг харуулж байна	38
Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт бүрэн хэрэгжихгүй байна.....	39
Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь хуульд заасан хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна	39
Дүгнэлт	41
Зөвлөмж	43
Хавсралтууд.....	53

**Товчилсон үгийн тайлбар**

ААН	Аж ахуй нэгж
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ННДГ	Нийслэлийн нийгмийн даатгалын газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ҮОМШӨДС	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдсан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл
ЭМНДЕГ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Капитал банканд байршуулсан хөрөнгийн эх үүсвэр	7
2	НДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
3	Шимтгэл төлөгч болон сангаас үйлчилгээ авагчдын мэдээлэл	8
4	Шимтгэл төлөгч болон тэтгэвэр авагчдын судалгаа	10
5	Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	11
6	Тэтгэврийн даатгалын санд олгосон улсын төсвийн санхүүжилт	12
7	Нэрийн дансны бүртгэл, тооцоолол	14
8	Албан журмын даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт	15
9	Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт	15
10	НДС-гаас тэтгэврийн үйлчилгээ авч чадаагүй нас барсан хүний тоо	15
11	Илүү тэтгэвэр олгогдсон нас барсан иргэний тоо	16
12	Нас барсны дараа сарын тэтгэвэр нь олгогдоогүй иргэний тоо	16
13	Засгийн газраас тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн шийдвэрүүд	17
14	Даатгуулагчийн НДШ илүү төлсөн болон буцаан олголт авсан мэдээлэл	19



15	Тэтгэврийн тооцоолол зөрүүтэй хийгдсэн даатгуулагчийн судалгаа	19
16	Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	20
17	Тэтгэмж авсан даатгуулагчийн мэдээлэл	20
18	ҮОМШӨДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээлэл	21
19	ҮОМШӨДС-гаас үйлчилгээ авагчдын мэдээлэл	22
20	ҮОМШӨДС-гийн бүрдүүлэлт	23
21	Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	23
22	Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авсан болон мэргэжлийн сургалтад хамрагдсан даатгуулагчийн мэдээлэл	24
23	Ажилгүйдлийн даатгалын даатгалын сангийн тэтгэмж олголтод хийсэн судалгаа	24
24	ЭМДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл	25
25	ЭМДС-гаас тусламж, үйлчилгээ авагчийн тоо, олгосон төлбөрийн хэмжээ	25
26	ЭМД-ын үйл ажиллагааны талаарх бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийх хугацаа	26
27	НДС-гийн чөлөөт үлдэгдлийн дүн	29
28	Банканд байршуулсан НДС-гийн чөлөөт үлдэгдэл жилийн эцсийн байдлаар	30
29	НДС-гийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын бонд худалдан авсан судалгаа	31
30	НДС-гийн чөлөөт үлдэгдлээс олсон хүүгийн орлогын судалгаа	31
31	НДС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний судалгаа	33
32	2012-2016 онд шинээр эхлүүлсэн ТАХ-ний зураг төсвийг баталгаажуулсан байдал	33
33	НДС-д бүртгэлтэй авлагын үлдэгдэл	38
34	Шимтгэлийн авлагын насжилт	39

Графикийн жагсаалт

Дугаар	Графикийн нэр	Хуудасны дугаар
1	ДНБ болон Нэгдсэн төсвийн нийт зарлагад НДС-гийн зарлагын эзлэх хувь, тэрбум төгрөгөөр	9
2	НДС-гийн зарлагад сангийн төрөл тус бүрийн эзэлж байгаа хувь	9
3	Тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвийн хариуцах ёстой тэтгэврийн хэмжээг хариуцаж байгаа тэтгэврийн хэмжээтэй харьцуулсан дүн	12
4	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээнээс өндөр цалин авч байгаа даатгуулагчийн тоо	18
5	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрт иргэнээс төлж байгаа зардлын хэмжээ	27
6	Сангуудын чөлөөт үлдэгдлийг дүн	29
7	НДС-гийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсан судалгаа	30
8	НДС-гийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	33
9	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	35
10	НДС-гийн орлогод эзлэх шимтгэлийн авлагын хэмжээ	37
11	НДШ-ийн авлагын үлдэгдэлд эзлэх шүүхийн шийдвэртэй авлагын хэмжээ	37
12	НДШ-ийн өглөгтэй байгууллагын тоо	38



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/45 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

НДС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Сангуудын тогтолцоо, хөрөнгийн зарцуулалт үр нөлөөтэй байгаа эсэх;
- НДС-гаас санхүүжүүлсэн хөрөнгийн болон нийгмийн хамгааллын зардлын зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Сангийн яам, ХНХЯ, ЭМЯ, НДЕГ, НДҮЗ, орон нутаг дахь нийгмийн даатгалын газар, хэлтэс, ЭМДЕГ, ЭМДҮЗ-ийн 2012-2018 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултуудад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан шалгах, баримт бичгийн шинжилгээ, харьцуулалт, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгаж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

НДС-гийн үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, нэмэлт мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, эрдэмтэн, судлаачдын бичсэн дүгнэлт тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль;
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль;
- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль;
- Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлох тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;



- Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр;
- Монгол Улсын Их Хурлын 1999 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”;
- Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”;
- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн дүрэм;
- Ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрөөг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоол;
- Дээрх хууль, эрх зүйн актуудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, норм норматив, стандарт, холбогдох бусад шийдвэр.

Аудитын хязгаарлалт:

Капитал банканд нийгмийн даатгалын 104.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын 136.1 тэрбум, нийт 240.3 тэрбум төгрөгийг байршуулснаас сангийн хөрөнгийг алдах эрсдэлд оруулсан асуудлыг Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанаас 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр эрүүгийн 1902002900121 дугаар хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгагдаж байна.

Хүснэгт 1. Капитал банканд байршуулсан хөрөнгийн эх үүсвэр

(тэрбум төгрөг)

Нэр	Тэтгэврийн даатгалын сан	Тэтгэмжийн даатгалын сан	ҮОМШӨ-ний даатгалын сан	ЭМД-ын даатгалын сан	Ажилгүйдлийн даатгалын сан	Нийт дүн
НДЕГ	1.4	2.2	62.0	0.2	38.5	104.2
ЭМДЕГ	-	-	-	136.1	-	136.1
Нийт дүн	1.4	2.2	62.0	136.3	38.5	240.3

Эх сурвалж: НДЕГ, ЭМДЕГ

ЭМДС 2017 оноос эхлэн бие даасан үйл ажиллагаа явуулж ЭМД-ын тогтолцооны үр нөлөөг тооцох хугацаа болоогүй, үйл ажиллагааны хамрах хүрээ нь өргөн, нарийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар шаардсан үйл явц бөгөөд аудитыг гүйцэтгэх явцад шалгагдагч байгууллагаас ирүүлсэн тайлбар мэдээлэл, бэлтгэсэн баримт материал нь нотлох зүйлсийн найдвартай, учир холбогдолтой, итгэл үнэмшил төрүүлэхүйц байх зэрэг зохистой шалгуурыг хангаагүй, сангийн үйл ажиллагааг цогц байдлаар аудитад хамруулан үнэлж, дүгнэх цаг хугацаа, боловсон хүчний нөөц хүрэлцээгүй, мэргэжлийн зөвлөх шинжээч ажиллуулах боломж бүрдээгүй зэргээс тэнцвэртэй, тайлан боловсруулах, дүгнэлт гаргах нөхцөл бүрдээгүй гэж үзсэн.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны захиалгаар хийгдсэн “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар хийсэн гүйцэтгэлийн аудитыг АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журам, нөхцөл байдалтай уялдуулан авч үзэхэд дээрх аудитыг хийсэн зорилтоос улбаалан “Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д бие даасан аудитыг хийх нь зүйтэй гэж дүгнэв.

Иймд дээрх 2 асуудлыг Гүйцэтгэлийн аудитын журмын 12.25-д заасны дагуу аудитын хамрах хүрээг хязгаарласан болно.

**ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын Нийгмийн даатгалын тогтолцоо нь “эв санаа”-ны зарчимд суурилсан хуваарилалтын хэлбэртэй (орлогоо зарлагад шууд хуваарилах) бөгөөд 1995 онд эрх зүйн орчныг бүрдүүлж, өнөөг хүртэл дагаж мөрдөж байна.

Нийгмийн даатгалын харилцаа нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн орлогыг тодорхой санд төвлөрүүлж, хууль тогтоомжид заасан шалгуур хангасан иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохоор зохицуулагдсан байна.

Нийгмийн даатгалын төрөл тус бүр нь дараах мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байна. Үүнд:

1. Тэтгэврийн даатгалын сан;
2. Тэтгэмжийн даатгалын сан;
3. Эрүүл мэндийн даатгалын сан;
4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан;
5. Ажилгүйдлийн даатгалын сан.

Хүснэгт 2. НДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт		Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Орлогын*	Төлөвлөгөө	1	720.2	971.5	1,249.6	1,222.6	1,257.5	1,468.0	1,301.4
	Гүйцэтгэл	2	798.8	1,018.4	1,141.6	1,187.9	1,315.0	1,544.0	1,480.2
Зөрүү (+илүү, -дутуу)		3=(2-1)	78.6	46.9	(108.0)	(34.7)	57.5	76.0	178.8
Зарлагын	Төлөвлөгөө	4	942.2	1,067.8	1,310.3	1,546.6	1,764.8	1,907.5	1,808.2
	Гүйцэтгэл	5	903.4	1,058.6	1,315.0	1,541.4	1,720.3	1,890.8	1,814.6
Зөрүү (+дутуу, - илүү)		6=(4-5)	38.8	9.2	(4.7)	(5.2)	(44.5)	16.7	(6.4)
Сангуудын	Ашиг	7	122.6	151.7	123.6	127.7	154.5	190.3	145.5
	Алдагдал**	8	(227.2)	(191.9)	(297.0)	(481.2)	(559.8)	(537.1)	(479.9)
Цэвэр алдагдал		9	-	-	(43.7)	(188.6)	(245.9)	(221.6)	(144.1)

Эх сурвалж: НДЕГ

* НДС-гийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд улсын төсвөөс олгох санхүүжилтийн дүн ороогүй болно.

** НДС-гийн цэвэр алдагдал биш бөгөөд энэ дүнд төр хариуцах цэргийн алба хаагчийн тэтгэвэр болон 1995 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийн зардлын дүн орсон болно.

НДС-гийн орлогын төлөвлөгөө 2014 онд 108.0 тэрбум, 2015 онд 34.7 тэрбум төгрөгөөр биелээгүй нь тухай онуудын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор НДШ төлөгчдийн тоо 33.1 мянгаар буурснаас шалтгаалсан байна.

Сангийн зарлага гүйцэтгэлээр 2014 – 2016 онд 4.7-44.5 тэрбум, 2018 онд 6.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс хэтэрч, сангийн алдагдлын хэмжээ 2014 – 2018 онд 43.7-245.9 тэрбум төгрөг байгаа нь УИХ-аас 2012 онд баталсан Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөө, Засгийн газрын шийдвэрээр инфляцын түвшинтэй уялдуулж тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмсэн болон 2008 онд тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 5 пунктээр бууруулсантай холбоотой байна.

Хүснэгт 3. Шимтгэл төлөгч болон сангаас үйлчилгээ авагчдын мэдээлэл

(даатгуулагчийн тоо)


Үзүүлэлт		2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Шимтгэл төлөгч ААН		30496	35461	39496	41648	43122	43580	45892
Даатгуулагч	Албан журмаар	742019	803887	832892	799798	799558	836487	907701
	Сайн дураар	101257	148168	185668	189238	228480	199143	196996
ЭМД-ын шимтгэлийг төр хариуцан төлсөн иргэдийн тоо		1469755	1658254	1823522	1798918	1514673	1759028	1763919
НДС-гаас үйлчилгээ авсан даатгуулагч	Тэтгэвэр	300134	307062	338843	356679	371640	388562	397009
	Тэтгэмж	150268	162505	178307	180256	182017	194400	209571
	ҮОМШӨ	11986	12097	11354	10615	10023	9621	9185
	Ажилгүйдэл	10521	15872	16315	18698	23203	21163	21423
	ЭМД	4126435	3843228	4452051	5042575	5708107	6860849	7317334

Эх сурвалж: НДЕГ, ЭМДЕГ-ын статистик мэдээ



НДС-д шимтгэл төлөгчийн тоог 2012 оныг 2018 онтой харьцуулахад ажил олгогч 50.5 хувиар, даатгуулагч 31.0 хувиар, ЭМД-ын шимтгэлийг төр хариуцан төлсөн иргэдийн тоо 20.0 хувиар тус тус өссөн, мөн НДС-гаас үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо 73.0 хувиар өссөн байна.


График 1. ДНБ болон Нэгдсэн төсвийн нийт зарлагад НДС-гийн зарлагын эзлэх хувь



Эх сурвалж: УСХ, НДЕГ

НДС-гийн зарлага 2012 – 2018 онд ДНБ-ий 5.4-7.2 хувьтай, нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 15.1-21.6 хувьтай тэнцүү байна.

График 2. НДС-гийн зарлагад сангийн төрөл тус бүрийн эзэлж байгаа хувь



Эх сурвалж: НДЕГ

НДС-гийн зарлагад тэтгэврийн даатгалын сан 75.0-89.2 хувь, тэтгэмжийн даатгалын сан 4.7-6.3 хувь, ҮОМШӨДС 1.8-3.0 хувь, ажилгүйдлийн даатгалын сан 0.8-1.9 хувь, ЭМДС 11.9-15.5 хувийг эзэлж байна.



БҮЛЭГ 1. БИЕ ДААСАН БАЙХ ЗАРЧИМД СУУРИЛСАН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс сангийн бие даасан байдал болон сангаас даатгуулагчид шударгаар үйлчилгээ үзүүлэх боломж алдагдаж байна

1.1 Монгол Улс иргэдийнхээ нийгмийн баталгааг хангах, аливаа эрсдэлээс хамгаалахын тулд 1995 онд шимтгэлд суурилсан тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрдүүлсэн байна.

1.2 УИХ-ын 1999 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”, 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого” /2015-2030/, 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын 2.2-д заасан Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилтод тэтгэврийн даатгалын бодлого, тогтолцоог тодорхойлсон бөгөөд түүний эрх зүйн орчныг бүрдүүлэх чиг үүргийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

1.3 Төрийн бодлогод сангийн бие даасан байдлыг сайжруулах, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалыг хуваарилалтын тогтолцооноос хагас болон бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжүүлэх, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжих зэргээр тусгасан байна.

1.4 Дээрх бодлогын зорилт, арга хэмжээг Монгол Улсын үе үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан боловч Монгол Улсын Засгийн газар төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго, зарчимд нийцүүлсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

1.5 Бодлогын хэрэгжилт хангалтгүй, өнөөгийн тэтгэврийн даатгалын тогтолцоо даатгуулагч бүрд тэтгэврийн даатгалын сангаас тэгш, шударгаар үйлчилгээ¹ үзүүлэх боломжийг бүрдүүлээгүй, тус сангийн бие даасан байх зарчим хангагдаагүй нь алдагдал өсөхөд нөлөөлж байна.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг албан журмын даатгалын хэлбэрээр нийгмийн даатгалын тогтолцоонд бүрэн хамруулах шаардлагатай байна

1.6 Улсын хэмжээнд тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлөгчийн тоог 2018 оныг 2012 онтой харьцуулахад ажил олгогч 15.4 мянга буюу 50.5 хувиар, даатгуулагч 261.4 мянга буюу 31 хувиар, сангаас тэтгэвэр авсан даатгуулагч 94.8 мянга буюу 30.9 хувиар тус тус өссөн байна. Энэ нь 3 шимтгэл төлөгчид 1 тэтгэвэр авагч ногдож байгааг харуулж байна.

Хүснэгт 4. Шимтгэл төлөгч болон тэтгэвэр авагчдын судалгаа

(даатгуулагчийн тоо)

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Шимтгэл төлөгч ААН	30496	35461	39496	41648	43122	43580	45892
Даатгуулагч	Албан журмаар	742019	803887	832892	799798	799558	836487
	Сайн дураар	101257	148168	185668	189238	228480	199143
Тэтгэвэр авагчийн тоо	306844	313558	344832	362174	376792	393477	401660

Эх сурвалж: НДЕГ

1.7 Монгол Улсын ажиллах хүчин 2018 онд 1358.6 мянга байгаагаас 70.1 хувийг 952.7 мянган даатгуулагч (шимтгэл төлөгчийн давхардсан тоог хассан дүнгээр) эзэлж, үүнээс 782.7 мянга нь албан журмаар, 170.0 мянга нь сайн дураар шимтгэл төлсөн байна².

¹ Тэтгэврийг даатгуулагчийн нийт төлсөн шимтгэлд үндэслэхгүй ажилласан жилийн дунджаар тогтоож байна.

² Эх сурвалж: УСХ, НДЕГ



1.8 Нийт ажиллах хүчний 29.9 хувь буюу 405.9 мянган иргэн тэтгэврийн даатгалын тогтолцооны гадна байгаагаас 45.8 хувийг 185.9 мянган малчин, 54.2 хувийг 220.0 мянган хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн эзэлж байна.

1.9 Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “... малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах нөхцөл, журмыг хуулиар тогтоож болно” гэж заасан боловч хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, Нийгмийн даатгалын байгууллагаас сайн дураар даатгуулах хэлбэрт хамруулж байгаа нь тэтгэврийн даатгалын хамрах хүрээ өргөжихгүй, нийгмийн даатгалын тогтолцооноос гадна үлдсэн иргэдийн нийгмийн баталгаа хангагдахгүй байх эрсдэл үүсгэж байна.

Нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийхгүйгээр алдагдлыг санхүүжүүлсэн байна

1.10 УИХ-аас НДС-гийн орлогын доод, зарлагын дээд хязгаарыг баталж, Сангийн сайдын тушаалаар сан тус бүрд хуваарилж байна.

Хүснэгт 5*. Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Орлогын	Төлөвлөгөө	1	446.7	606.0	785.2	750.6	743.8	834.6
	Гүйцэтгэл	2	491.8	634.8	705.3	719.0	767.8	880.3
Зөрүү (+илүү, -дутуу)		3=(2-1)	45.1	28.8	(79.9)	(31.6)	24.0	45.7
Зарлагын	Төлөвлөгөө	4	451.7	560.7	673.6	857.4	996.5	1,095.4
	Гүйцэтгэл	5	439.1	562.1	749.0	899.3	1,006.5	1,101.9
Зөрүү (+ дутуу, - илүү)		6=(4-5)	12.6	(1.4)	(75.4)	(41.9)	(10.0)	(6.5)
Ашиг, алдагдал		7=(2-5)	52.7	72.7	(43.7)	(180.3)	(238.7)	(221.6)
								(144.1)

* Тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дүнгээс улсын төсвөөс олгосон санхүүжилт, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дүнгээс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэний болон цэргийн албан хаагчийн тэтгэврийн зардлыг тус тус хассан дүнгээр илэрхийлсэн болно.

Эх сурвалж: НДЕГ

1.11 Тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөлт 2014 онд 79.9 тэрбум, 2015 онд 31.6 тэрбум төгрөгөөр дутуу, зарлагын төлөвлөгөө 2013-2017 оны хооронд 1.4-75.4 тэрбум төгрөгөөр хэтэрсэн байна.

1.12 Тэтгэврийн даатгалын сан 2014-2018 онд 43.7-238.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу алдагдлын хэмжээ ДНБ-ий 0.06-1.0 хүртэл хувьд хүрсэн нь:

- Сангийн орлогын төлөвлөгөө 2014, 2015 онд дутуу биелсэн нь эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор албан журмын даатгуулагчийн тоо 33.1 мянгаар буурснаас;
- Сангийн зарлага төлөвлөснөөс хэтэрч, алдагдалтай байсан нь Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөө болон Засгийн газраас тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулж үе шаттай нэмсэн зэргээс шалтгаалсан байна.

1.13 Тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улсын төсвийн татаас болон сангийн чөлөөт үлдэгдлээс санхүүжүүлэхдээ тухайн оны НДС-гийн төсвийн тухай хуульд тодотгол хийгээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1³ дэх хэсэгт заасныг зөрчсөн байна.

1.14 Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3⁴ дахь хэсэгт заасны дагуу **1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэний** тэтгэврийг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5⁵ дугаар зүйлд заасны дагуу **цэргийн алба хаагчийн** тэтгэврийг улсын төсвөөс тус тус санхүүжүүлж байна.

³ Нийгмийн даатгалын сан тус бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг Улсын Их Хурал батална.

⁴ Нийгмийн даатгалын тодорхой төрлийн санд улсын төсвөөс энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн үүргийн дагуу тэтгэвэр, тэтгэмжид олгох хөрөнгийг жил бүр Төсвийн тухай хуулиар тогтооно.

⁵ Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийг улсын төсвөөр санхүүжүүлнэ. Санхүүжилтийг нийгмийн даатгалын санд шилжүүлэх журмыг Засгийн газар тогтооно.



Хүснэгт 6. Тэтгэврийн даатгалын санд олгосон улсын төсвийн санхүүжилт

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Улсын төсвөөс авах авлага*	1	239.7	259.1	282.9	309.2	313.9	315.4	335.8
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	2	272.7	264.6	253.3	292.6	494.9	570.2	594.9
Зөрүү	3=(1-2)	33.0	5.5	(29.6)	(16.6)	181.0	254.8	259.1

Эх сурвалж: НДЕГ

1.15 Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс 2014 онд 29.6 тэрбум, 2015 онд 16.6 тэрбум төгрөгөөр дутуу, бусад онд 5.5-259.1 тэрбум төгрөгөөр илүү санхүүжилт олгосон байна.

1.16 Улсын төсвөөс олгосон тухайн жилийн санхүүжилт нь цэргийн алба хаагч болон 1995 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт зарцуулагдаж, үлдсэн санхүүжилтээр тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхсөн байна.


Шимтгэлд суурилсан тэтгэврийн даатгалын тогтолцоонд шилжсэнээс хойш тэтгэвэр тогтоолгосон иргэний 1995 оноос өмнөх хугацаанд ажилласан жилд ногдох тэтгэврийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр тодорхойгүй, сангаас санхүүжүүлж байгаа нь санг алдагдалд оруулах суурь шалтгаан болсон байна

1.17 Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоог 2019 оны эхний хагас жилийн байдлаар НДЕГ-т ашиглагдаж байгаа программ хангамжийн мэдээллийн сангаас гаргуулж харахад нийт 414358 иргэн хамрагдсан байна⁶. Тэтгэвэрт хамрагдсан иргэдийн ажилласан хугацааг сараар авч үзэхэд нийт 118.1 сая сар, үүнээс 1995 оноос өмнөх жилүүдэд хамаарах нь 77.5 сая сар буюу 65.6 хувь, харин 1995 оноос хойш тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлсөн хугацаанд хамаарах нь 40.6 сая сар буюу 34.4 хувь байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

1.18 Дээрх байдлаас дүгнэж үзэхэд нийт тэтгэврийн зардлын 34.4 хувийг сан, харин 65.6 хувийг төр хариуцахаар байна. График 3-ыг үзнэ үү.

График 3. Тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвийн хариуцах ёстой тэтгэврийн хэмжээг хариуцаж байгаа тэтгэврийн хэмжээ

(харьцуулсан дүн, хувь)



Эх сурвалж: НДЕГ

1.19 Гэтэл тэтгэврийн даатгалын сангаас улсын хэмжээнд тэтгэвэр авагчдад 2018 онд олгосон нийт 1,619.3 тэрбум төгрөгийн тэтгэврийн 609.8 тэрбум төгрөг буюу 37.7 хувийг улсын төсөв, 1,009.5 тэрбум төгрөг буюу 62.3 хувийг сангаас санхүүжүүлсэн байна.

1.20 Дээрх графикаас харахад 2018 онд тэтгэвэр авагчдад олгосон нийт санхүүжилтийн 1,062.3 тэрбум төгрөг буюу 65.6 хувийг төр хариуцах, 557.0 тэрбум төгрөг буюу 34.4 хувийг тэтгэврийн даатгалын сан хариуцахаар байна. Тооцооллын зөрүү болох 452.5 тэрбум

⁶ Эх сурвалж: НДЕГ-ын тооцоололд үндэслэв.



төгрөгийг төр хариуцахгүйгээр тэтгэврийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа нь тус санг алдагдалд оруулах суурь шалтгаан болсон байна.

1.21 Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэний тэтгэвэр, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу цэргийн алба хаагчийн тэтгэврийг төр хариуцан улсын төсвөөс санхүүжүүлж байгаа хэдий ч нийгмийн даатгалын тогтолцоо бүрдсэн 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн санд шимтгэл төлөөгүй хугацаанд ногдох тэтгэврийг сангаас бүрэн санхүүжүүлж байгаатай холбоотой байна.

1.22 Даатгалын сан 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэний 1995 оноос өмнөх хугацаанд ажилсан жилд ногдох тэтгэврийн зардлыг хариуцаж, үйлчилгээ үзүүлж байгаа нь шударга байх зарчим алдагдах, одоо шимтгэл төлж байгаа даатгуулагчийн санд итгэх итгэл буурах, хуримтлал үүсэхгүй алдагдал нэмэгдэх үр дагавартай байна.

Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөгөөр санд 37.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 704.6 тэрбум төгрөгийн зарлага гарсан нь тэтгэврийн даатгалын санг алдагдалд оруулахад нөлөөлсөн байна

1.23 УИХ-аас 2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулиар 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэний ажилласан жил нь тасарсан хугацааг ажилласнаар нөхөн тооцох, 1995-2000 оны хооронд НДШ нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэний даатгуулагч өөрөө төлөх 10 хувийг тухайн онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төлүүлэн НДШ-ээ төлсөнд тооцуулахаар зохицуулагдсан байна.

1.24 Дээрх хуулийн хүрээнд Нийгмийн даатгалын төв байгууллага 607.8 мянган иргэний ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож, тэтгэврийн даатгалын санд 37.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

1.25 Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан иргэдээс 2019 оны 08 дугаар сарын байдлаар тэтгэврээ шинээр тогтоолгосон 140.6 мянган иргэнд 552.6 тэрбум, тэтгэврээ өөрчлөн тогтоолгосон 92.4 мянган иргэнд 152.0 тэрбум, нийт 233.0 мянган иргэнд 704.6 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

1.26 Тэтгэвэрт зарцуулсан дүн тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлсэн мөнгөн дүнгээс 18.6 дахин их байгаа нь тус санг алдагдалд оруулахад нөлөөлсөн бөгөөд сангийн бие даасан байх зарчим алдагдаж, төрөөс үйл ажиллагаа нь хараат байгаатай холбоотой байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлал үүсгэж мөнгөжүүлэх асуудал эрх зүйн зохицуулалтгүй байна

1.27 Даатгуулагчийн төлсөн шимтгэл тэтгэвэрт нь бүрэн зориулагдах шударга хуваарилалтын зарчмыг үндэслэн тэтгэврийн хэмжээг тогтоох хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд УИХ-ын 1999 оны 38 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”-д нэрийн дансны тогтолцоог нэвтрүүлэхээр тусгаж, УИХ-аас 1999 онд Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг баталж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

1.28 Энэ хуулиар тэтгэврийн даатгалд даатгуулсан 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, уг дансны эхний үлдэгдэл, даатгуулагчийн төлсөн шимтгэл, хүүг тооцох, нэрийн данснаас тэтгэвэр тогтоон олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байсан бол УИХ-ын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/-д нэрийн дансны тогтолцоонд үндэслэн тэтгэвэр тогтоох



даатгуулагчийн хугацааг 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн иргэн болгон өөрчилсөн байна.

1.29 Нийгмийн даатгалын төв болон орон нутгийн байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэврийн даатгалын санд даатгуулагчийн нэрийн дансыг хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хүснэгт 7. Нэрийн дансны бүртгэл, тооцоолол

(тэрбум төгрөг)

Он	Даатгуулагчийн тоо*	Эхний үлдэгдэл	Хөдөлмөрийн хөлс	Бүртгэсэн шимтгэл	Хүү			Эцсийн үлдэгдэл
					Эхний үлдэгдэл	Бүртгэсэн шимтгэл	Хувь	
2000	539579	412.9	136.8	19.0	53.7	2.5	13.0	488.0
2001	563233	488.0	105.9	18.2	68.3	2.5	14.0	577.1
2002	596054	577.1	137.6	23.4	80.8	3.3	14.0	684.6
2003	627807	684.6	172.0	29.3	34.2	1.5	5.0	749.6
2004	660626	749.6	226.3	38.4	82.5	4.2	11.0	874.7
2005	699979	874.7	282.5	47.8	61.2	3.3	7.0	987.0
2006	741365	987.0	390.7	65.4	109.6	7.3	11.1	1,169.2
2007	787860	1,169.2	544.7	90.3	184.7	14.3	15.8	1,458.4
2008	845261	1,458.4	970.5	118.1	272.7	22.1	18.7	1,871.3
2009	895991	1,871.3	1,138.2	138.0	557.6	41.1	29.8	2,608.1
2010	957201	2,608.1	1,452.5	175.3	738.1	49.6	28.3	3,571.2
2011	1036206	3,571.2	2,088.3	251.2	907.1	63.8	25.4	4,793.3
2012	1118201	4,793.3	3,108.3	368.0	987.4	75.8	20.6	6,224.5
2013	1201261	6,224.5	3,922.4	463.2	1,388.1	103.3	22.3	8,179.1
2014	1267658	8,179.1	4,760.3	562.9	1,521.3	104.7	18.6	10,368.1
2015	1319784	10,368.1	5,186.0	607.7	1,057.5	62.0	10.2	12,095.3
2016	1381155	12,095.3	5,594.2	651.6	955.5	51.5	7.9	13,753.9
2017	1436040	13,753.9	6,501.3	759.2	921.5	50.9	6.7	15,485.5
2018**	-	15,485.5	7,054.1	959.1	-	-	-	-

* Нас барсан, урьд нь даатгуулж байгаад одоо хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүний тоо орсон дүнгээр.

** НДҮЗ-ийн шийдвэрээр жил бүрийн бүртгэгдсэн шимтгэлийн дүнг хүүгээр өсгөх эрх зүйн зохицуулалттай бөгөөд 2018 онд Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох журмыг шинэчлэн боловсруулахаас шалтгаалан хүүгийн дүнг батлаагүй байна.

Эх сурвалж: НДЕГ

1.30 Монгол Улсын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд 2017 онд 1.4 сая иргэн бүртгэгдэж, 15,485.5 тэрбум төгрөгийн хийсвэр тооцоолол хийгдсэн байна.

1.31 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлал үүсгэж, түүнийг мөнгөжүүлэх ажил хийгдээгүй, хийсвэр бүртгэл, тооцоололтой тэтгэвэр бодох аргачлал хэлбэрээр хэрэгжиж байгаа нь холбогдох эрх зүйн орчин бүрдээгүйгээс шалтгаалсан байна.

1.32 Энэ нь иргэдийн ирээдүйн орлого баталгаажихгүй, төлсөн шимтгэлээ хуримтлалын зарчмаар өсгөж тэтгэвэртээ бүрэн эгүүлэн авах боломж бүрдэхгүй байх эрсдэлийг дагуулсан байна.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмсэн шийдвэр нь ажил олгогч, даатгуулагчийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдахгүй байна

1.33 Тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлөх хувь хэмжээ нь тэтгэврийн даатгалын орлого, зарлагын зохистой харьцааг хангах, хамрах хүрээг нэмэгдүүлэх, цаашид хуримтлал үүсгэж иргэдийн ирээдүйн орлогыг баталгаажуулах, сангийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх чухал хүчин зүйл юм.

1.34 Монгол Улсад 1995 оноос шимтгэлд суурилсан тэтгэврийн даатгалын тогтолцоо бүрдэж, шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 13.5 хувиар, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос 5.5 хувиар буюу нийт 19.0 хувиар, сайн дурын даатгуулагч 9.5 хувиар тус тус төлөхөөр хуульчилж баталсан байна.

1.35 УИХ-аас 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг



ажил олгогчоос 6.5 пунктээр бууруулж 7 хувь, даатгуулагчаас 1.5 пунктээр нэмэгдүүлж 7 хувь буюу нийт 14.0 хувиар, сайн дурын даатгуулагчаас 0.5 пунктээр нэмэгдүүлж 10.0 хувиар тогтоосон байна.

1.36 Энэ өөрчлөлтөөр ажил олгогчийн төлөх шимтгэлийг тодорхой хувиар бууруулсан нь ААН-ийн үйл ажиллагааг дэмжихэд, даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэмснээр иргэдийн бодит орлого буурахад нөлөөлсөн байна.

1.37 УИХ-аас 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар **тэтгэврийн даатгалын** шимтгэлийн хувь хэмжээг 2018 оноос эхлэн гурван жилийн хугацаанд ажил олгогч болон даатгуулагч тус бүр 1.0, 0.5, 1.0 пунктээр (нийт 5.0 пунктээр) нэмэгдүүлж, ажил олгогч 9.5 хувиар, даатгуулагч 9.5 хувиар нийт 19.0 хувиар, сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийг 2.5 пунктээр нэмэгдүүлж 12.5 хувиар тогтоосон байна.

Хүснэгт 8. Албан журмын даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт

(хувь)

№	Даатгалын төрөл	1995-2007 он		2008-2012 он		2013-2016 он		2017 он		2018 он		2019 он	
		Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч	Ажил олгогч	Даат-гуулагч
1	Тэтгэврийн даатгал	13.5	5.5	7.0	7.0	7.0	7.0	7.0	7.0	8.0	8.0	8.5	8.5
Нийт		19		14		14		14		16		17	

Эх сурвалж: Нийгмийн даатгалын тухай хууль

Хүснэгт 9. Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээний өөрчлөлт

(хувь)

№	Даатгалын төрөл	1995-2007 он	2008-2017 он	2018 он	2019 он
1	Тэтгэврийн даатгал	9.5	10	11	11.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын тухай хууль

1.38 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 5 пунктээр өсгөх шийдвэр гаргасан нь даатгуулагч ирээдүйд тэтгэвэр өндөр тогтоолгох боломж бүрдэх хэдий ч өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд НДШ төлөгч 45892 ААНБ-ын 21897 буюу 47.7 хувь нь 116.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын өртэй, ядуурлын хамралтын хүрээ 2018 онд 28.4 хувьтай байгаа нөхцөлтэй уялдахгүй байна.

1.39 Харин тэтгэврийн даатгалын санд чөлөөт үлдэгдлийг бий болгох, түүнийг эрсдэлгүй, үр ашигтай удирдах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр сангийн үйл ажиллагааг тогтвортой явуулах боломж байна.

Нас барсан иргэдийн төлсөн шимтгэлийг хэрхэх талаар эрх зүйн зохицуулалтгүйгээс даатгуулагч хохирох эрсдэл үүссэн байна

1.40 НДС-д шимтгэл төлсөн иргэд сангаас үйлчилгээ авч чадахгүйгээр нас барсан тохиолдолд тухайн даатгуулагчийн төлсөн шимтгэлийг хэрхэх асуудал одоогийн нийгмийн даатгалын тогтолцоонд зохицуулагдаагүй байгаа нь даатгуулагч хохирох эрсдэл үүсгэж байна.

Хүснэгт 10. НДС-гаас тэтгэврийн үйлчилгээ авч чадаагүй нас барсан хүний тоо

Д/д	Хүйс	Насны бүлэг	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1	Эмэгтэй	50-54	470	527	530	494	491	475	472
2	Эрэгтэй	55-59	1009	1058	1064	1188	1273	1268	1306
Нийт			1479	1585	1594	1682	1764	1743	1778

Эх сурвалж: УСХ

1.41 Монгол Улсын хэмжээнд 50-54 настай нас барсан эмэгтэй хүн, 55-59 настай нас барсан эрэгтэй хүний тоог аудитад хамрагдсан 2012-2018 оноор гаргахад нийт 11625 хүн байна.



1.42 Дээрх нас барсан иргэдийн тодорхой хувь нь *(нас барсан иргэдийн хэдэн хувь нь НДШ төлж байсныг аудитаар тогтооход хязгаарлагдмал байна)* НДШ төлж байсан бөгөөд эдгээр хүмүүсийн төлсөн шимтгэл сангийн орлогоор үлдэж байна.

1.43 Цаашид НДС-гийн үйлчилгээг шударга байх зарчимд нийцүүлэхийн тулд нас барсан иргэдийн төлсөн шимтгэлийг хэрхэх талаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Эрүүл мэндийн болон бүртгэлийн байгууллага хооронд мэдээллийг цаг тухайд нь шуурхай солилцох программ хангамжийн дутагдалтай байдлаас шалтгаалж нас барсан хүнд илүү тэтгэвэр олгох нөхцөл бүрдсэн байна

1.44 Нийслэлийн хэмжээнд НДС-гаас тэтгэвэр авч байгаад 2015-2018 онд эрүүл мэндийн байгууллагад нас барсан иргэдийн бүртгэлийг НЭМГ-аас авч, тэтгэвэр зогсоосон хугацаатай нь тулган баталгаажуулахад 9 дүүргийн 18591 нас барсан иргэнээс 75 хүнд 143 сарыг илүү тооцож, 53.2 сая төгрөгийн тэтгэврийг олгосон байна. (Бусад газар нас барсан иргэний мэдээллийг тулгаагүй болно.)

Хүснэгт 11. Илүү тэтгэвэр олгогдсон нас барсан иргэний тоо

(сая төгрөг)

Д/д	Дүүргийн нэр	Илүү тэтгэвэр олгогдсон нас барсан иргэний тоо	Илүү тэтгэвэр олгосон сар	Мөнгөн дүн
1	Баянгол дүүрэг	3	4	1.6
2	Баянзүрх дүүрэг	20	41	18.4
3	Багануур дүүрэг	1	1	0.3
4	Багахангай дүүрэг	1	2	0.6
5	Налайх дүүрэг	9	13	3.4
6	Сүхбаатар дүүрэг	10	13	4.3
7	Сонгинохайрхан дүүрэг	22	48	17.6
8	Хан-Уул дүүрэг	3	4	1.4
9	Чингэлтэй дүүрэг	6	17	5.6
Нийт		75	143	53.2

Эх сурвалж: НЭМГ, ННДГ

1.45 Орон нутаг дахь нийгмийн даатгалын нэгжүүд нас барсан хүний тэтгэврийг зогсоохдоо тухайн иргэнийг нас барсныг гэрчилж улсын бүртгэлээс олгосон гэрчилгээг үндэслэл болгодог боловч эрүүл мэндийн байгууллагад иргэний нас барсан өдөр нь гэрчилгээнд заасан өдрөөс зөрүүтэй байна.

1.46 Энэ нь төрийн байгууллага хооронд мэдээлэл шуурхай солилцох нөхцөл бүрдээгүйгээс шалтгаалсан байна.

Нас барсан иргэний дараагийн сарын тэтгэврийг олгоогүй зөрчил илэрсэн байна

1.47 НДС-гаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд тэтгэвэр олгох хугацааг тэтгэвэр тогтоолгосон өдрөөс эхлэн нас барсны дараагийн сарыг дуустал олгох эрх зүйн зохицуулалтай байна.

Хүснэгт 12. Нас барсны дараагийн сарын тэтгэвэр нь олгогдоогүй иргэний тоо

(сая төгрөг)

Д/д	Дүүргийн нэр	Нас барсны дараагийн сарын тэтгэвэр нь олгогдоогүй иргэний тоо	Мөнгөн дүн
1	Баянгол дүүрэг	63	23.5
2	Баянзүрх дүүрэг	63	22.1
3	Багануур дүүрэг	3	0.7
4	Багахангай дүүрэг	0	0
5	Налайх дүүрэг	12	4.8
6	Сүхбаатар дүүрэг	5	6.5
7	Сонгинохайрхан дүүрэг	53	16.4
8	Хан-Уул дүүрэг	14	4.0
9	Чингэлтэй дүүрэг	21	7.3
Нийт		247	85.3

Эх сурвалж: ННДГ



1.48 Нийслэлийн хэмжээнд НДС-гаас тэтгэвэр авч байгаад 2015-2018 онд нас барсан 9 дүүргийн 18,591 иргэний улсын бүртгэлээс олгосон нас барсны гэрчилгээг тэтгэвэр нь зогссон хугацаатай тулган баталгаажуулахад 247 иргэнд 85.3 сая төгрөгийн тэтгэврийг олгоогүй зөрчил илэрсэн байна.

1.49 Энэ нь дүүргийн НДХ нийслэлийн хэмжээнд нас барсан хүний мэдээллийг улсын бүртгэлийн гэрчилгээ гарахаас өмнө “Улаанбаатар Буян” ХХК-аас авч, тэтгэврийг нь зогсоож, нас барсан иргэний хамаарал бүхий этгээд нас барсан иргэний дараа сарын тэтгэврийг авах эрх зүйн зохицуулалтыг мэдэхгүйгээс шалтгаалж тэтгэвэр олгогдохгүй байх нөхцөл бүрдсэн байна.

Засгийн газар тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, гаргасан шийдвэрийн үр нөлөөг бүрэн хариуцахгүй байгаа нь сангийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлсөн байна

1.50 Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээгээ хэрэгжүүлэхийн тулд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулж үе шаттай нэмсэн байна.

Хүснэгт 13. Засгийн газраас тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн шийдвэрүүд

Д/д	Засгийн газрын тогтоолын огноо, дугаар	Авсан арга хэмжээний агуулга (төгрөг)	Тухайн жилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг)	Хамрагдсан хүний тоо (мянган хүн)
1	2012 оны 80 дугаар	Бүрэн тэтгэвэр – 140,300.0 Хувь тэнцүүлсэн – 105,200.0 Тэтгэврийн хэмжээг 35,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэх	31.8	303.2
2	2012 оны 153 дугаар	Бүрэн тэтгэвэр – 180,300.0 Хувь тэнцүүлсэн – 145,200.0 Итгэлцүүрийг шинэчлэн, Тэтгэврийн хэмжээг 23.0 хувиар нэмэгдүүлэх	84.7	-
3	2014 оны 15 дугаар	Бүрэн тэтгэвэр – 207,300.0 Хувь тэнцүүлсэн – 172,200.0 Итгэлцүүрийг шинэчлэн, Тэтгэврийн хэмжээг 22,000.0/27,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэх	98.5	319.0
4	2015 оны 52 дугаар	Бүрэн тэтгэвэр – 230,000.0 Хувь тэнцүүлсэн – 195,000.0 Тэтгэврийн хэмжээг 20,000.0/22,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэх	102.2	341.7
5	2016 оны 292 дугаар	Бүрэн тэтгэвэр – 251,000.0 Хувь тэнцүүлсэн – 216,000.0 Тэтгэврийн хэмжээг 21,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэх	54.4	369.0
6	2018 оны 16 дугаар	Бүрэн тэтгэвэр – 280,000.0 Хувь тэнцүүлсэн – 243,000.0 Тэтгэврийн хэмжээг 27,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэх	119.5	-
7	2019 оны 26 дугаар	Бүрэн тэтгэвэр – 310,000.0 Хувь тэнцүүлсэн – 270,000.0 Тэтгэврийн хэмжээг 24,000.0 төгрөгөөр нэмэгдүүлэх	119.5	-

Эх сурвалж: НДЕГ

1.51 Засгийн газар 2012 оноос хойш тэтгэврийн хэмжээг 7 удаа нэмэгдүүлэх шийдвэр гаргасны дүнд бүрэн тэтгэврийн доод хэмжээ 140.3-310.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 105.2-270.0 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 162.0-375.2 мянган төгрөгт хүрч, тус тус 2.2-2.6 дахин нэмэгдсэн байна.



1.52 Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдон гарсан зардлыг дараа оны улсын төсөвт баталж, НДС-д нэг удаа олгож байгаа ч тухайн шийдвэр гарснаас хойших хугацааны зардлыг тэтгэврийн даатгалын сан бүрэн хариуцаж байгаа нь санг алдагдалд оруулахад нөлөөлсөн байна.

1.53 Засгийн газар гаргасан шийдвэрийнхээ үр нөлөөгөөр гарч байгаа холбогдох зардлыг дараагийн жилүүдэд бүрэн хариуцахгүй байгаагаас сангийн бие даасан зарчим алдагдсантай холбоотой байна.


Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс өндөр цалин авч байгаа даатгуулагчийн ажил олгогчоос төлж байгаа шимтгэлийн дүн тэтгэвэр тогтоолгоход нөлөөлөх эрх зүйн зохицуулалтгүй байна

1.54 Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт ажил олгогч, даатгуулагчийн НДШ төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Засгийн газар жил бүр батлахаар хуульчилсан байна.

1.55 Хуулийн дагуу Засгийн газар НДШ төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэгт заасан хувь хэмжээгээр буюу тухайн ажил олгогчийн сарын нийт хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоор тогтоосон байна.

1.56 Гэвч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн НДШ төлсөн, сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 45 хувиар тогтоохоор хуульчилсан байна.

График 4. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээнээс өндөр цалин авч байгаа даатгуулагчийн тоо



Эх сурвалж: НДЕГ

1.57 Монгол Улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс өндөр цалин авч байсан даатгуулагч 2012 онд 15095 байсан бол 2018 онд 20850 болж, 38.1 хувиар өссөн байна.

1.58 Дээрх даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг тогтооход хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс илүү гарсан дүнд ногдох ажил олгогчийн төлсөн шимтгэл нөлөөлөхгүй байгаа нь ажил олгогч, даатгуулагчийг хохироох эрсдэлтэй байна. Энэ нь тэтгэвэр тогтооход тооцох орлогын дээд хэмжээг эрх зүйн зохицуулалтад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар заасантай холбоотой байна.



Нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчид илүү төлсөн шимтгэлээ буцаан авах талаар мэдээлэл өгөөгүй, эрх зүйн зохицуулалтад мэдээлэл өгөх асуудал тусаагүй зэргээс шимтгэлээ илүү төлсөн даатгуулагчийн 90.2-99.3 хувь буцаан олголтгоо аваагүй байна

1.59 Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн НДЕГ-ын даргын 2013 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/197 дугаар тушаалаар “Даатгуулагчийн үндсэн ажил олгогчоос гадна нэгээс дээш байгууллагад ажиллан илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох аргачлал”-ыг баталсан байна.

1.60 Тус аргачлалд тухайн сард үндсэн ажил олгогчоос гадна нэгээс дээш байгууллагад ажилласан даатгуулагчийн цалин хөлс, орлогын нийлбэр дүн нь Засгийн газрын тогтоосон тухайн үед мөрдөж буй шимтгэл ногдуулах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс хэтэрч, уг хэтэрсэн хэмжээнээс шимтгэл төлсөн бол илүү төлсөн шимтгэлээ хүсэлт гарган буцаан авч болохоор зохицуулагдсан байна.

Хүснэгт 14. Даатгуулагчийн НДШ илүү төлсөн болон буцаан олголт авсан мэдээлэл

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Нийгмийн даатгалын шимтгэл илүү төлсөн даатгуулагч /тоо/	20165	14738	11299	11529	13640	9942	12455
Илүү төлсөн шимтгэлийн дүн /сая төгрөг/	2,337.9	3,735.9	2,233.5	2,545.0	2,655.7	2,334.1	3,381.7
Үүнээс:							
Илүү төлсөн шимтгэлээ буцаан авсан даатгуулагч	Тоо	146	611	431	751	612	980
	Хувь	0.7	4.1	3.8	6.5	4.5	9.8
Буцаан олгосон илүү төлсөн шимтгэлийн дүн	Сая төгрөг	19.3	238.1	250.2	626.5	603.6	1,058.5
	Хувь	0.8	6.4	11.2	24.6	22.7	45.3

Эх сурвалж: НДЕГ

1.61 Улсын хэмжээнд 2012-2018 онд давхар ажил эрхэлж тухайн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээнээс илүү шимтгэл төлсөн 9942-20165 даатгуулагч байна.

1.62 Эдгээр даатгуулагчийн 90.2-99.3 хувь нь илүү төлсөн шимтгэлээ буцаан аваагүй байгаа нь нийгмийн даатгалын байгууллагаас даатгуулагчид илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтын талаар мэдээлэл өгөөгүй, эрх зүйн зохицуулалтад мэдээлэл өгөх асуудал тусаагүйтэй холбоотой байна.

Тэтгэврийг хууль, журмын дагуу тогтоохгүй байгаа суурь шалтгааныг арилгаагүйгээс тэтгэврийг илүү болон дутуу тогтоох асуудал жил бүр давтагдан гарсаар байна

1.63 Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа иргэдийн хувийн хэргээс түүвэрлэн авч хууль тогтоомжийн дагуу тэтгэврээ тогтоолгуулсан эсэхийг тулган шалгахад нийгмийн даатгалын улсын байцаагч тэтгэврийг зөрүүтэй тооцсоны улмаас 154 иргэнд 164.8 сая төгрөг илүү, 226 иргэнд 22.4 сая төгрөгийг дутуу олгосон зөрчил илэрснийг хүснэгтээр дор харуулав.

Хүснэгт 15. Тэтгэврийн тооцоолол зөрүүтэй хийгдсэн даатгуулагчийн судалгаа

(хүний тоо, сая төгрөг)

Д/д	Аймгийн нэр	Тэтгэвэр илүү олгосон		Тэтгэвэр дутуу олгосон	
		Иргэний тоо	Мөнгөн дүн	Иргэний тоо	Мөнгөн дүн
1	Архангай	2	2.2	-	-
2	Баянхонгор	2	1.3	5	1.9
3	Булган	5	1.3	10	2.2
4	Говь-Алтай			3	0.6
5	Говьсүмбэр	1	0.1	8	0.7
6	Дорнод			42	1.6
7	Дундговь	1	0.3	2	0.1



8	Завхан	17	4.4	25	4.1
9	Сүхбаатар	86	12.6	75	3.7
10	Сэлэнгэ	8	2.8	51	5.8
11	Хөвсгөл	4	0.5	4	0.8
12	Увс	2	0.4	-	-
13	Төв	26	138.9	1	0.9
	ДҮН	154	164.8	226	22.4

Эх сурвалж: ТАБ

1.64 Энэ нь НДҮЗ хуульд заасан НДС-гаас тэтгэвэр, тэтгэмж тогтоох тогтолцоог боловсронгуй болгоогүй, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулаагүйгээс тэтгэвэр, тэтгэмжийг зөрүүтэй тогтоох асуудал жил бүр давтагдан гарсаар байгаа нь сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, даатгуулагч хохирох эрсдэл үүсгэж байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас санхүүжүүлэх жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн төсвийн төлөвлөлтийг хийх аргачлалыг сайжруулах шаардлагатай байна

1.65 Тэтгэмжийн даатгалын сангийн орлогын доод болон зарлагын дээд хязгаарыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу НДҮЗ-өөс батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж байна.

Хүснэгт 16. Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Орлогын	Төлөвлөгөө	1	32.5	68.5	87.2	85.5	82.9	103.1
	Гүйцэтгэл	2	35.4	67.3	78.4	81.1	86.9	112.7
Зөрүү (+илүү, -дутуу)		3=(2-1)	2.9	(1.2)	(8.8)	(4.4)	4.0	9.6
Зарлагын	Төлөвлөгөө	4	41.1	57.5	73.3	88.8	104.8	102.0
	Гүйцэтгэл	5	42.6	58.7	78.5	89.5	94.1	100.2
Зөрүү (+дутуу, - илүү)		6=(4-5)	(1.5)	(1.2)	(5.2)	(0.7)	10.7	1.8
Ашиг, алдагдал		7=(2-5)	(7.2)	8.6	(0.1)	(8.3)	(7.2)	12.6

Эх сурвалж: НДЕГ

1.66 Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 2012-2015, 2018 онд 0.7-9.7 тэрбум төгрөгөөр хэтэрсэн, сан 2012 онд 7.2 тэрбум, 2014-2016 онд 0.1-8.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь төрөлт нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд цаашид жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулах хөрөнгийг төсөвлөх аргачлалыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

1.67 Тэтгэмжийн даатгалын сангийн алдагдлыг тус сангийн чөлөөт үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хууль тогтоомжид нийцүүлэн олгоогүй байна

1.68 Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид ХЧТА-ы тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, оршуулгын тэтгэмжийг олгож байна.

Хүснэгт 17. Тэтгэмж авсан даатгуулагчийн мэдээлэл

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1	ХЧТА-ы тэтгэмж авсан даатгуулагч	Хүний тоо	98911	104393	112383	109070	110549	123336	133918
	ХЧТА-ы тэтгэмжид олгосон дүн	Тэрбум төгрөг	8.1	10.2	12.1	12.4	12.8	16.1	17.9



2	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан даатгуулагч	Хүний тоо	38483	45710	53035	58032	58132	57769	61507
	Жирэмсний болон амаржсаны тэтгэмжид олгосон дүн	Тэрбум төгрөг	30.6	44.7	58.3	66.5	68.4	70.6	79.9
3	Оршуулгын тэтгэмж авсан даатгуулагч	Хүний тоо	12874	12402	12889	13154	13336	13295	14146
	Оршуулгын тэтгэмжид олгосон дүн	Тэрбум төгрөг	3.9	3.7	8.1	8.2	11.1	13.3	14.1

Эх сурвалж: НДЕГ

1.69 ХЧТА-ны тэтгэмж авсан даатгуулагчийн тоо 2012 оныг суурь болгон авч үзэхэд 2018 онд сэтгэцийн эмгэг, дотор, мэдрэл, гэмтэл согог, нүдний өвчний тохиолдол нэмэгдсэнээс 35.4 хувиар, жирэмсний болон амаржсаны тэтгэмж гэрлэлт нэмэгдсэнээс 59.8 хувиар тус тус өссөн байна.

1.70 Тэтгэмжийн даатгалын сангаас хууль тогтоомжид нийцүүлэн тэтгэмж олгосон эсэхийг шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

- **Жирэмсний болон амаржсаны тэтгэмж:**
Завхан аймагт 1 иргэнд 0.01 сая төгрөгийг илүү, 2 иргэнд 0.1 сая төгрөгийг дутуу олгосон.
- **Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж:**
Сүхбаатар аймагт 84 иргэнд 9.0 сая төгрөгийг цалинтай давхардуулж;
Сэлэнгэ аймагт 3 иргэнд 0.5 сая төгрөгийг дутуу;
Хөвсгөл аймагт 1 иргэнд 0.4 сая төгрөгийг дутуу;
Увс аймагт 5 иргэнд 0.6 сая төгрөгийг илүү, 5 иргэнд 0.1 сая төгрөгийг дутуу олгосон.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл жил бүр дунджаар 20.7 хувийн өсөлттэй байна

1.71 УИХ-аас НДС-гийн орлогын доод болон зарлагын дээд хязгаарыг баталж, Сангийн сайдын тушаалаар ҮОМШӨДС-гийн төсвийг хуваарилсан байна.

Хүснэгт 18. ҮОМШӨДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээлэл

Үзүүлэлт		Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Орлогын	Төлөвлөгөө	1	53.4	73.2	90.3	108.5	106.7	136.2	140.3
	Гүйцэтгэл	2	67.9	86.6	99.8	109.8	125.2	147.8	171.2
Зөрүү (+илүү, -дутуу)		3=(2-1)	14.5	13.4	9.4	1.3	18.4	11.6	30.9
Зарлагын	Төлөвлөгөө	4	29.9	34.3	34.6	36.3	39.7	48.0	48.7
	Гүйцэтгэл	5	27.0	31.5	32.3	33.5	31.0	46.0	46.8
Зөрүү (+дутуу, - илүү)		6=(4-5)	2.8	2.9	2.4	2.8	8.8	1.9	1.9
Ашиг, алдагдал		7=(2-5)	40.9	55.1	67.5	76.3	94.2	101.8	124.4

Эх сурвалж: НДЕГ

1.72 ҮОМШӨДС-гийн орлогын төлөвлөгөө аудитын хамрах хүрээний 2012-2018 онд 1.3-30.9 тэрбум төгрөгөөр давж, зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 1.9-8.8 тэрбум төгрөгөөр хэтэрсэн ч сангийн чөлөөт үлдэгдэл жил бүр дунджаар 20.7 хувийн өсөлттэй байна.

Үйлдвэрлэлийн осолд өртсөн даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг сэргээх рашаан сувиллын газрыг хүртээмжтэй байхаар зохион байгуулаагүйгээс баруун бүсийн аймгуудад хамрагдалт 5.5 хувьтай байна

1.73 ҮОМШӨДС-гаас тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, ХЧТА-ы тэтгэмж, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл, даатгуулагчийг сувилахад ногдох тусламж, үйлчилгээний хувьсах зардал болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг тус тус олгож байна.



Хүснэгт 19. ҮОМШӨДС-гаас үйлчилгээ авагчдын мэдээлэл

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1	Тахир дутуугийн тэтгэвэр авагч	Тоо	6023	5824	5378	4902	4573	4347	4118
	Тахир дутуугийн тэтгэврийн дүн	Тэрбум төгрөг	22.6	24.5	24.9	24.7	24.1	23.7	23.9
2	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч	Тоо	687	672	611	593	579	568	533
	Тэжээгчээ алдсаны тэтгэврийн дүн	Тэрбум төгрөг	2.2	2.4	2.4	2.4	2.5	2.5	2.6
3	ХЧТА-ы тэтгэмж авагч	Тоо	798	1014	841	993	1009	1098	1061
	ХЧТА-ы тэтгэмжийн дүн	Тэрбум төгрөг	0.3	0.5	0.4	0.6	0.6	0.6	0.7
4	ХЧНС-тэй холбогдсон төлбөр авагч	Тоо	30	34	26	26	22	20	17
	ХЧНС-тэй холбогдсон төлбөрийн дүн	Тэрбум төгрөг	0.03	0.04	0.04	0.03	0.03	0.02	0.02
5	Рашаан сувиллын зардал авсан хүн	Тоо	3097	3159	2936	2886	2653	2465	2432
	Рашаан сувиллын зардлын дүн	Тэрбум төгрөг	0.80	0.82	0.79	1.14	1.06	0.97	0.95
6	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын дүн	Тэрбум төгрөг	0.12	-	0.16	0.38	0.38	0.71	0.8
7	Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн дүн	Тэрбум төгрөг	0.71	0.78	0.89	0.85	0.6	0.85	0.87
Нийт хамрагдсан хүн		Тоо	10635	10703	9792	9400	8836	8498	8161
Нийт зарлагын дүн		Тэрбум төгрөг	26.8	29.0	29.6	30.1	29.3	29.4	29.8

Эх сурвалж: НДЕГ

1.74 ҮОМШӨДС-гаас санхүүжүүлж байгаа зарим зардал хуульд заасан зорилгод нийцээгүй, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй байна. Тухайлбал,

■ **Рашаан сувиллын хувьсах зардлын тухайд:**

Улсын хэмжээнд 2012-2018 оны байдлаар нийт 35165 тахир дутуугийн тэтгэвэр авагчдад (давхардсан тоогоор) рашаан сувилалд сувилуулах эрх үүссэнээс хамрагдалт 53.2 хувьтай байна. Үүнээс хамгийн бага буюу баруун бүсийн аймгуудад хамрагдалт 5.5 хувь байгаа бол хамгийн их буюу төвийн бүсийн аймгуудад хамрагдалт 67.6 хувьтай байгаа нь НДҮЗ-ийн 2003 оны 18, 2008 оны 18 дугаар тогтоолоор тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа даатгуулагчийг сувилуулах сувиллын газрыг (Тулга, Да-Оюут, Эрдэнэт, Агаар, Багануур, улсын үйлчилгээтэй рашаан сувилал) нэр зааж баталсан, тахир дутуугийн тэтгэвэр авагчийг рашаан, сувилалд явахад дагалдах асран хамгаалагчийн зардлыг сангаас санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтгүй, даатгуулагчдад сангаас авах үйлчилгээний талаар мэдээлэл өгдөггүй зэргээс шалтгаалсан байна.

■ **Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын тухайд:**

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны дарга урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө, зардлыг жил бүр баталдаг. Зардлын төлөвлөгөө 2012-2018 онд 50.0-72.7 хувийн биелэлттэй байгаа ч сургалтын үр дүнг тооцоогүй байна.

1.75 ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон сувилуулах шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тэдэнд сувиллыг ойртуулах зорилгоор НДҮЗ-ийн 2017 оны 06 дугаар тогтоолоор НДС-гаас олгох “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах журам” болон ЭМНДЕГ-ын даргын А/90 тоот “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал”-ыг тус тус баталсан боловч дээрх журмууд нь Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүйгээс өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил мэргэжлийн онцлогтой нийцүүлэн тогтоох эрх зүйн зохицуулалтгүй байна

1.76 ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн хариуцан төлдөг бөгөөд шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 0.8-2.8 хувиар ялгавартай тогтоож байна.

1.77 Ялгавартай шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу НДҮЗ-



ийн саналыг харгалзан Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 3.0 болон 2.0 хувиар төлөх ажил олгогчийн жагсаалт”-ыг баталж, түүнд Засгийн газрын 2017 оны 17 дугаар тогтоолоор “шимтгэлийг 2.8 болон 1.8 хувиар” төлөхөөр хувийг бууруулж өөрчилсөн байна.

1.78 ҮОМШӨДС-д 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 46775 ажил олгогч 105.5 тэрбум төгрөгийн шимтгэл төлснөөс 1.8 болон 2.8 хувиар буюу ялгавартай шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо нийт дүнд 25.2 хувийг эзэлж байгаа ч төлсөн шимтгэл нь 72.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 20. ҮОМШӨДС-гийн бүрдүүлэлт, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Шимтгэл төлж буй хувиар			Нийт дүн
		0.8 хувь	1.8 хувь	2.8 хувь	
Ажил олгогч	Тоо	35007	9676	2092	46775
	Нийт дүнд эзлэх хувь	74.8	20.7	4.5	100.0
Даатгуулагчийн тоо	Тоо	541680	173995	128435	844110
	Нийт дүнд эзлэх хувь	64.2	20.6	15.2	100.0
Төлсөн шимтгэл	Тэрбум төгрөг	29.4	24.1	52	105.5
	Нийт дүнд эзлэх хувь	27.9	22.8	49.3	100.0

Эх сурвалж: НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвийн мэдээлэлд суурилав.

1.79 Уул уурхай, эрчим хүч, газрын тосны салбарыг хүнд нөхцөлийн ангилалд оруулж ялгавартай нөхцөлөөр ҮОМШӨДС-д шимтгэл төвлөрүүлэхдээ дээрх ажил олгогчийн удирдлага, захиргаа, санхүү аж ахуйн ажилтнуудыг хүнд нөхцөлд ажиллаж буй ажилтнуудтай адилтган шимтгэл тооцож байгаа нь эрх зүйн зохицуулалтгүйгээс шалтгаалсан байна.

1.80 Иймд ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөл, эрсдэлээс хамааруулан тогтоодог эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 2018 онд 2012 онтой харьцуулахад 4.8 дахин буурсан байна

1.81 Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын доод болон зарлагын дээд хязгаарыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу НДҮЗ батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг тус тус баталж байна.

Хүснэгт 21. Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Орлогын	Төлөвлөгөө	1	35.4	21.4	26.3	27.8	31.4	37.4
	Гүйцэтгэл	2	37.2	25.7	26.3	29.8	32.5	41.1
Зөрүү (+илүү, -дутуу)		3=(2-1)	1.8	4.3	(0.0)	2.0	1.1	3.7
Зарлагын	Төлөвлөгөө	4	11.1	15.3	18.4	25.7	28.1	35.8
	Гүйцэтгэл	5	7.0	16.1	19.1	23.4	32.0	34.7
Зөрүү (+дутуу, - илүү)		6=(4-5)	4.1	(0.8)	(0.7)	2.3	(3.9)	1.1
Ашиг, алдагдал		7=(2-5)	30.2	9.6	7.2	6.4	0.5	6.3

Эх сурвалж: НДЕГ

1.82 Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө аудитын хамарсан хугацаанд давж биелсэн, зарлагын төлөвлөгөө 2013 онд 0.8 тэрбум, 2014 онд 0.7 тэрбум, 2016 онд 3.9 тэрбум төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Харин тус сангийн чөлөөт үлдэгдэл 2018 оныг 2012 онтой харьцуулахад 4.8 дахин буурсан байна. Энэ нь:

- Төрийн албан хаагчийг тогтвор, суурьшилтай ажиллуулаагүй;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сунгаагүйгээс уул уурхайн салбарт ажилгүйдэл өссөн;



- Тэтгэмж авсан даатгуулагчийн тоо 2012 оноос 2018 онд 2 дахин нэмэгдсэн;
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн өөрчлөлтөөр шимтгэлийн хувь хэмжээг 0.6 пунктээр бууруулсан;
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр хүчингүй болгож ажилгүйдлийн тэтгэмжийг ажлаас чөлөөлөгдсөн шалтгаанаас үл хамааран 40 хоног байсныг 76 хоног болгосон зэргээс шалтгаалсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлын нэг хүнд ногдох дээд хэмжээнд 2001 оноос хойш өөрчлөлт оруулаагүйгээс мэргэжлийн сургалтад хамруулах хуулийн зорилт хангагдахгүй байна

1.83 Ажилгүйдлийн даатгалын сангаас 2012-2018 онд 127112 хүн ажилгүйдлийн тэтгэмж авч, үүнээс 72 хүн мэргэжлийн сургалтад хамрагдаж, 3.6 сая төгрөгийг сургалтад зарцуулснаас харахад мэргэжлийн сургалтад хамруулах хуулийн зорилт хангагдахгүй, ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэдийг сургах бодлого үр нөлөөгүй байна.

Хүснэгт 22. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авсан болон мэргэжлийн сургалтад хамрагдсан даатгуулагчийн мэдээлэл

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгосон хүн /тоогоор/	10471	15871	16315	18698	23203	21131	21423
Сургалтын зардлын төлөвлөгөө /сая төгрөгөөр/	36.2	43.8	51.5	192.0	96.0	96.0	96.0
Мэргэжлийн сургалтад хамрагдсан хүн /тоогоор/	50	1	-	-	-	21	-
Сургалтад зарцуулсан төлбөр /сая төгрөгөөр/	2.5	0.1	-	-	-	1.1	-

Эх сурвалж: НДЕГ

1.84 Энэ нь тухайн ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэнийг дараагийн ажлын байранд орох хүртэлх хугацаанд үр дүнтэй сургах бодлого байхгүй, Засгийн газрын 2001 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоолоор “... , Ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлын нэг хүнд ногдох дээд хэмжээг 50.0 мянган төгрөгөөр тогтоосон ...” зэргээс тус тус шалтгаалсан байна.

1.85 Ажилгүйдлийн даатгалын сангаас хууль тогтоомжид нийцүүлэн тэтгэмж олгосон эсэхийг түүврийн аргаар тулган шалгахад 11 аймагт 64 даатгуулагчид тэтгэмжийн хэмжээг 67.3 сая төгрөгөөр илүү, 20 даатгуулагчид 6.2 сая төгрөгөөр дутуу тогтоож олгосон зөрчил илэрснийг хүснэгтээр дор харуулав.

Хүснэгт 23. Ажилгүйдлийн даатгалын даатгалын сангийн тэтгэмж олголтод хийсэн судалгаа
(хүний тоо, сая төгрөг)

Д/д	Аймгийн нэр	Тэтгэмж илүү олгосон		Тэтгэмж дутуу олгосон	
		Иргэний тоо	Мөнгөн дүн	Иргэний тоо	Мөнгөн дүн
1	Архангай	2	2.6	4	1.9
2	Баянхонгор	4	8.9	5	1.3
3	Булган	4	0.8	5	0.6
4	Дархан-Уул	10	4.3	-	-
5	Дундговь	2	1.2	-	-
6	Завхан	5	4.3	4	1.0
7	Өмнөговь	9	20.5	-	-
8	Төв	3	4.1	-	-
9	Орхон	1	3.2	-	-
10	Сэлэнгэ	12	4.3	2	1.4
11	Хөвсгөл	12	13.1	-	-
	ДҮН	64	67.3	20	6.2

Эх сурвалж: ТАБ

**Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт төлөвлөснөөс хэтрээгүй байна**

1.86 ЭМДС-гийн орлогын доод болон зарлагын дээд хязгаарыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу НДҮЗ батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг тус тус баталж байна.

Хүснэгт 24. ЭМДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Мөр	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Орлогын	Төлөвлөгөө	1	152.2	202.3	260.6	250.7	292.8	356.4
	Гүйцэтгэл	2	166.5	204	231.8	248.1	302.7	364.1
Зөрүү (+илүү, -дутуу)		3=(2-1)	14.3	1.7	-28.8	-2.6	9.9	35.1
Зарлагын	Төлөвлөгөө	4	135.6	131.4	190.3	216.8	271.5	316.9
	Гүйцэтгэл	5	114.9	125.6	182.9	203.1	242.8	292.2
Зөрүү (+дутуу, - илүү)		6=(4-5)	20.7	5.8	7.4	13.7	28.7	24.7
Ашиг, алдагдал		7=(2-5)	51.6	78.4	48.9	45.0	59.9	71.9
								98.7

Эх сурвалж: НДЕГ, ЭМДЕГ

1.87 ЭМДС-гийн орлогын төлөвлөгөө 2014-2015 онд 2.6-28.8 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь улсын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор даатгуулагчдын тоо буурснаас шалтгаалжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо болон зардлын хэмжээ тогтмол өсөлттэй байна

1.88 ЭМДС-гаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад дараах тусламж, үйлчилгээ хамаарч байна. Үүнд:

- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ;
- Амбулаторийн үзлэг, хяналт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ;
- Өдрийн эмчилгээ, үйлчилгээ;
- Хорт хавдрын болон бусад өвчний хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ;
- Уламжлалт, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээ;
- Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл;
- Өрх, сум, баг, аймаг, дүүргийн амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн бичсэн жороор олгох эмийн үнийн хөнгөлөлт;
- Зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгсэл;
- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ;
- Хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ;
- Жирэмсний 37 долоо хоногоос өмнөх ба төрсний дараах үеийн хавсарсан эмгэгийн эмчилгээ;
- Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ.

1.89 Дээрх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь дараах зардлын төрлөөр санхүүжигдсэн байна.

Хүснэгт 25. ЭМДС-гаас тусламж, үйлчилгээ авагчийн тоо, олгосон төлбөрийн хэмжээ

Төрөл	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Улсын төсвийн эмнэлэгт олгосон	мянган хүн	3203.3	2752.2	3109.4	3446.8	3817.8	4536.0	4915.1
	тэрбум төгрөг	89.8	89.5	128.6	141.4	170.4	198.2	213.2
Мэс заслын тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хувийн хэвшлийн эмнэлэгт олгосон зардал	мянган хүн	75.7	89.1	93.5	109.7	121.1	284.7	309.9
	тэрбум төгрөг	7.0	7.9	10.3	11.2	11.7	36.2	37.6
Рашаан сувилалд олгосон зардал	мянган хүн	54.9	58.7	67.9	71.5	81.9	94.2	91.4
	тэрбум төгрөг	3.9	4.3	7.4	7.7	9.2	10.4	10.1
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	мянган хүн	706.9	854.5	1073.3	1286.3	1564.9	1526.5	1370.3
	тэрбум төгрөг	4.9	9.7	11.6	16.4	27.3	26.8	25.9
Хувийн хэвшлийн эмнэлэгт олгосон зардал	мянган хүн	85.7	88.7	108.0	128.3	122.4		
	тэрбум төгрөг	8.7	9.2	16.7	19.4	20.1		
		мянган хүн	-	-	-	-	419.5	548.4



Элэг бүтэн монгол хөтөлбөр	тэрбум төгрөг	-	-	-	-	-	18.7	19.8
Өрхийн эмнэлэгт олгосон зардал	мянган хүн	-	-	-	-	-	-	82.2
	тэрбум төгрөг	-	-	-	-	-	-	1.7
Нийт тусламж, үйлчилгээ авсан даатгуулагч	мянган хүн	4126.4	3843.2	4452.1	5042.6	5708.1	6860.9	7317.3
Нийт тусламж, үйлчилгээний зардал	тэрбум төгрөг	114.4	120.7	174.7	196.1	238.5	290.3	308.3

Эх сурвалж: НДЕГ

1.90 ЭМДС-гаас төлбөрийг нь хариуцсан тусламж, үйлчилгээний 2018 оны үзүүлэлтийг 2012 онтой харьцуулахад даатгуулагчийн тоо 1.8, зардлын хэмжээ 2.7 дахин өссөн байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан нь даатгалын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог алдагдуулж болзошгүй байна

1.91 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1⁷-д ЭМД-ын газар нь ХНХС-ын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдаж байсныг УИХ-ын 2016 оны 12, Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор ЭМС-ын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн байна.

1.92 УИХ-ын 2017 оны 78 дугаар тогтоолоор ЭМС-ыг ЭМДҮЗ-ийн гишүүн болон зөвлөлийн даргын албан тушаалд томилсон байна.

1.93 ЭМД-ын үйл ажиллагааг ЭМС-ын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн нь даатгалын асуудлаар шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулсан ч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн харьяалалд орсноор хяналтын тогтолцоог алдагдуулна гэж үзэж байна.

Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны талаарх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна

1.94 Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 143, НДҮЗ-ийн 2012 оны 10 дугаар тогтоол, Эрүүл мэнд, Сангийн болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 270/168/108 дугаар тушаалаар Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн бодлого, стратегийн баримт бичгийг баталсан байна.

1.95 Дээрх баримт бичигт ЭМД-ын хамрах хүрээг 98 хувьд хүргэх, мэдээлэл шуурхай солилцох болон мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, даатгуулагчийн үндсэн мэдээллийг агуулсан цахим картын тогтолцоог нэвтрүүлэх зэрэг бодлогын зорилт, арга хэмжээг тусгасан байна.

1.96 Гэвч бодлогын хэрэгжилт хангалтгүй, зорилт, арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байгаа нь бодлогын баримт бичигт тусгасан хугацаанд үнэлгээг хийж, үр дүнг тооцоогүй, бодлого хэрэгжүүлэх талаар арга хэмжээ аваагүйгээс шалтгаалсан байна.

1.97 Холбогдох байгууллагууд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 2012, 2016, 2017 онд үнэлгээ хийж, үр дүнг тооцох байжээ.

Хүснэгт 26. ЭМД-ын үйл ажиллагааны талаарх бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийх хугацаа

Д/д	Бодлогын баримт бичгийн нэр	Үнэлгээ хийх хугацаа	Хариуцсан байгууллага
1	Эрүүл мэндийн санхүүжилтийн асуудлаарх стратегийн баримт бичиг /2010-2015 он/	2012 он	ЭМЯ

⁷ Эрүүл мэндийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан Үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын нийгмийн даатгалын байцаагчаас бүрдэнэ.




2	Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги /2013-2022 он/	2017 он	ХАХНХЯ, ЭМЯ
3	Нийгмийн даатгалын байгууллагын эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны хөгжлийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөө /2012-2016 он/	2016 он	НДҮЗ-ийн ажлын алба

Эрүүл мэндийн нийт зардалд хувь хүний төлөх төлбөрийн эзлэх хэмжээ 2012-2015 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон түвшнээс өндөр байна

1.98 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн нийт зардалд иргэний төлөх төлбөрийн эзлэх хэмжээ 30 хүртэл хувь байна гэж тодорхойлсон байна.

1.99 ЭМС, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2010 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 270/168/109 тушаалаар баталсан “Эрүүл мэндийн санхүүжилтийн 2010-2015 оны стратеги”-д “иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өөрөөсөө төлж байгаа шууд төлбөрийн хэмжээг улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэн төлбөртэй үйлчилгээний хүрээг хумих замаар 20 хувь хүртэлх бууруулах...”, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 143 дугаар тогтоолоор сайшаагдсан “Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги”-д 25 хувь хүртэл бууруулах зорилтыг дэвшүүлсэн боловч 2012-2015 онд⁸ 30.3-37.5 хувьтай байгаа нь зорилт, арга хэмжээнээс 2.3-12.5 пунктээр өндөр байна.

График 5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрт иргэнээс төлж байгаа зардлын хэмжээ, хувиар



Эх сурвалж: ЭМЯ

1.100 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрт ЭМДС-гаас санхүүжүүлж байгаа зардлын хэмжээ бага, хувь хүнээс гарах зардал Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон түвшнээс өндөр байгаа нь иргэний амьжиргааны түвшинг бууруулах үр дагавартай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын тодорхой хувийг хариуцах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 2014 оноос хойш шинэчлэн батлаагүй нь иргэнээс төлж байгаа зардал өсөхөд нөлөөлсөн байна

1.101 Даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлын ЭМДС-гаас олгох хэмжээг ЭМС, Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2013 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн 459/280/182 тушаалаар шинэчлэн тогтоож, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ЭМД-ын гэрээ бүхий улсын эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авах тохиолдолд тухайн өвчний оношноос нь хамааран дунджаар 300.0 мянган төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэгт дунджаар 175.0 мянган төгрөгийг ЭМДС-гаас төлөхөөр шийдвэрлэжээ.

1.102 НДҮЗ-ийн 2016 оны 19 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг баталсан боловч зардлыг тооцож өөрчлөлт оруулаагүй байна.

1.103 Жишээ нь эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх “Бөөр шээсний замын бусад мэс засал” оношны бүлгийн тусламж, үйлчилгээний төлбөр 1 хүнд дунджаар 2014 онд 329.8 мянган төгрөг байсан бол 2018 онд 674.5 мянган төгрөг болж 2 дахин нэмэгдсэн байна. Гэвч ЭМД-

⁸ 2016-2018 оны иргэний хувиасаа төлж байгаа зардлын хэмжээг эцэслэн баталгаажуулаагүй байна.



аас олгох тусламж, үйлчилгээний зардлын хэмжээ 2014 оноос тогтоосон хэмжээ нь хэвээр байгаа нь иргэний өөрөөсөө төлж байгаа зардлыг нэмэгдүүлж байна.

Хуулийн дагуу байгуулах эрсдэлийн нөөцийн санг байгуулаагүй байна

1.104 Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт ЭМДС-гийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг болзошгүй эрсдэлийн нөөцөд үлдээж болох бөгөөд зарцуулах журмыг НДҮЗ батлахаар заажээ.

1.105 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна” гэж заасны дагуу 2016 онд орлогын 3.2 тэрбум, 2017 онд 3.4 тэрбум, 2018 онд 3.5 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгасан боловч Сангийн яамнаас төсөв өргөн барих явцад хасагдсанаас шалтгаалан санг байгуулаагүй байна.

1.106 Энэ нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр ЭМДС алдагдалд орсон тохиолдолд сангийн тогтвортой байдал хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлаа гэр бүлийн өөр нэг гишүүнд шилжүүлэх хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байна

1.107 НДҮЗ-ийн 2014 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах журам”-аар ЭМД-ын шимтгэлээ жил бүр тогтмол төлсөн, дараалсан 3 жилийн хугацаанд ЭМД-ын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг эрүүл мэндийн бүрэн үзлэгт нэг удаа хамруулж урамшуулахаар заажээ.

1.108 Дээрх журмын дагуу 2014-2016 онд 20,670 хүн урамшуулалд хамрагдаж, 1.6 тэрбум төгрөгийг олгосон байна. Харин Эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсанаас хойш тус хуулийн 9 дүгээр зүйлийн 4⁹ дэх хэсэгт заасны дагуу урамшуулал олгох журмыг ЭМДҮЗ шинэчлэн батлаагүй байна.

1.109 Мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8¹⁰-д “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр нь тухайн жилийн дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч гишүүний зөвшөөрснөөр, түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах”-аар заасан боловч энэхүү заалтыг нийтэд таниулах үйл ажиллагаа хангалтгүйгээс хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2017 онд зөвхөн 1 даатгуулагч 286.0 мянган төгрөгийг гэр бүлийн гишүүний зардлаас шилжүүлэн тооцуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг эрсдэлгүй, үр ашигтай удирдах эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна

1.110 НДС-гийн чөлөөт үлдэгдэл гэж Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар батлагдсан зарлагаас давсан мөнгөн хөрөнгө юм.

⁹ Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлот хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд урамшуулал олгох журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.

Энэ хуулийн 6.1.1-6.1.4, 6.1.9, 6.1.12-т заасан даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр нь тухайн жилийн дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд гэр бүлийн өөр нэг даатгуулагч гишүүний зөвшөөрснөөр, түүний зардлаас жилд нэг удаа шилжүүлэн тооцуулах.



1.111 Өнөөгийн эрх зүйн орчны хүрээнд сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах, Монголбанкны үнэт цаас болон Засгийн газрын бонд худалдаж авах зэргээр өсгөн нэмэгдүүлэхээр байна.

1.112 НДС-гийн чөлөөт үлдэгдэл 2012-2018 оны хооронд 411.7-1,097.0 тэрбум төгрөгийн хооронд байсан бөгөөд мөнгөн хөрөнгийг арилжааны банканд хадгаламж болон харилцах дансны үлдэгдэл хэлбэрээр байршуулж байна.


Хүснэгт 27. НДС-гийн чөлөөт үлдэгдлийн дүн

Он	Төвлөрсөн харилцах	Тэтгэвэр	Тэтгэмж	ҮОМШӨ	ЭМД	Ажилгүйдэл	Нийт дүн	Үүнээс:	
								Хадгаламж	Харилцах
2011	3.5	162.0	11.9	52.1	108.9	61.4	399.8	98.0	301.8
2012	5.3	180.6	6.8	57.0	103.7	58.3	411.7	163.0	248.7
2013	8.6	295.5	15.3	140.4	250.2	106.1	816.1	245.0	571.1
2014	5.4	231.5	17.8	172.7	269.3	112.4	809.1	532.0	277.1
2015	6.3	81.1	11.8	217.7	298.0	85.0	699.9	467.0	232.9
2016	6.4	34.2	8.1	338.5	367.8	117.7	872.6	583.0	289.6
2017	2.0	65.3	16.8	442.0	444.4	126.4	1,097.0	450.6	646.4
2018	4.2	149.1	32.8	608.6	575.0	142.0	1,511.7	855.3	656.4
2019.6	9.5	242.0	42.5	618.7	701.4*	104.3	1,718.4	1,060.6	657.8

*2019 оны 12 дугаар сарын дүн

Эх сурвалж: НДЕГ

График 6. Сангуудын чөлөөт үлдэгдлийн дүн




Эх сурвалж: НДЕГ

1.113 НДС-гийн чөлөөт үлдэгдлийн 10.0 буюу түүнээс дээш хувийг 2012-2018 оны хооронд Голомт банк, Капитал банк, Төрийн банк, Төрийн сан, Хаан банк, Улаанбаатар хотын банк, Хадгаламж (хуучин нэрээр) банканд байршуулсан бөгөөд бусад банкнууд 10.0-аас доош хувийг эзэлсэн байна. (Банканд байршуулсан чөлөөт үлдэгдлийн эх үүсвэрийг хавсралт 2-оос харна уу)



График 7. НДС-гийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсан судалгаа

(хувиар)



Эх сурвалж: НДЕГ

1.114 НДС-гийн чөлөөт үлдэгдлийг 2012-2019 оны 6 сар хүртэл хугацаанд банканд байршуулснаас харахад Капитал банк болон Улаанбаатар хотын банк нийт чөлөөт үлдэгдлийн 16.9-51.7 хүртэл хувийг эзэлж байна.

Хүснэгт 28. Банканд байршуулсан НДС-гийн чөлөөт үлдэгдэл жилийн эцсийн байдлаар

(тэрбум төгрөг)

Д/д	Банкны нэр	2012 он		2013 он		2014 он		2015 он		2016 он		2017 он		2018* он		2019 оны 06* сар	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Голомт	41.4	10.1	31.2	3.8	29.2	3.6	51.4	7.3	72.9	8.4	114.4	10.4	139.5	14.7	151.4	14.5
2	Капитал	31.4	7.6	126.4	15.5	209.5	25.9	238.1	34.0	224.1	25.7	228.2	20.8	105.3	11.1		
3	Капитрон	7.6	1.8	20.6	2.5	13.2	1.6	20.6	2.9	37.8	4.3	42.3	3.9	47.6	5.0	56.3	5.4
4	Кредит	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	19.2	1.8
5	Төрийн банк	2.2	0.5	187.3	23.0	157.8	19.5	87.1	12.4	75.6	8.7	94.0	8.6	148.4	15.7	177.8	17.1
6	Төрийн сан	113.2	27.5	244.5	30.0	84.3	10.4	45.0	6.4	113.0	12.9	104.1	9.5	83.9	8.9	94.9	9.1
7	Тээвэр хөгжил	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	46.3	4.9	46.1	4.4
8	УБ хотын банк	38.3	9.3	56.6	6.9	178.2	22.0	124.0	17.7	170.2	19.5	183.9	16.8	85.8	9.0	121.1	11.6
9	ҮХОБ			5.1	0.6	15.2	1.9	15.7	2.2	36.0	4.1	57.2	5.2	33.3	3.5	10.9	1.0
10	Хаан	38.0	9.2	99.8	12.2	59.2	7.3	45.9	6.6	31.6	3.6	65.6	6.0	137.4	14.5	229.0	22.0
11	Хадгаламж	94.0	22.8														
12	Хас	0.3	0.1	0.6	0.1	0.9	0.1	0.8	0.1	0.5	0.1	1.8	0.2	1.5	0.2	3.5	0.3
13	ХХБ	32.0	7.8	19.8	2.4	7.4	0.9	7.7	1.1	50.8	5.8	79.6	7.3	22.3	2.4	40.7	3.9
14	Чингис хаан	13.1	3.2	24.3	3.0	54.2	6.7	63.6	9.1	60.2	6.9	125.8	11.5	96.5	10.2	91.2	8.7
15	БНСУ-ын банкууд	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.0	0.1	0.0
	Нийт	411.7	100.0	816.1	100.0	809.1	100.0	699.9	100.0	872.6	100.0	1,097.0	100.0	948.0	100.0	1,042.2	100.0

Эх сурвалж: НДЕГ

*2018, 2019 оны дүнд ЭМДС-гийн чөлөөт үлдэгдэл тусгагдаагүй болно.

1.115 Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл болон нийгмийн даатгалын байгууллагын удирдлага НДС-гийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгаламж хэлбэрээр байршуулахдаа хүүгийн түвшнийг Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс багаар хадгалуулах гэрээг байгуулсан байна. Энэ нь сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх илүү орлого олох боломжийг алдсан, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан байж болзошгүй байна. (Чөлөөт үлдэгдлийн мөнгөн хадгаламжийн хүүг Монголбанкны бодлогын хүүтэй харьцуулсан судалгааг хавсралт 3-аас харна уу)

1.116 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар эрх олгосны дагуу 2012-2017 онд нийт 415.1 тэрбум төгрөгийн бонд худалдан авсан байна.



Хүснэгт 29. НДС-гийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын бонд худалдан авсан судалгаа

(тэрбум төгрөг)

Он	Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар бонд худалдан авах эрх олгосон		Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр		Засгийн газрын дотоод үнэт цаас гаргасан		НДС-ийн хөрөнгөөр бонд худалдан авсан		Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл	
	Батлагдсан огноо	Хөрөнгийн дээд хэмжээ	Огноо	Хөрөнгийн дээд хэмжээ	Мөнгөн дүн	Жигнэсэн дундаж хүү	Мөнгөн дүн	Хүүгийн түвшин	Огноо	Мөнгөн дүн
2012	2011.11.30	60.0	2012.09.14	210.0	881.6	12.8	218.1	8.29	2012.12.31	188.1
2014	2013.11.15	-	2014.12.18	200.0	2,588.6	12.8	90.0	12	2014.12.31	90.0
2015	2014.11.14	400.0		-	2,545.5	14.6	50.0	12	2015.12.31	140.0
2016	2015.11.13	400.0		-	3,902.5	12.9	-	12	2016.12.31	57.0
2017	2016.11.10	100.0		-	3,376.6	14.2	57.0	9	2017.12.31	57.0
2018	2017.11.14	300.0		-	-		-		2018.12.31	-
	Нийт дүн	1,260.0		410.0	13,294.8		415.1			-

Эх сурвалж: НДЕГ

1.117 Засгийн газрын бондын нэрлэсэн хүү чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсан хадгаламжийн хүүгээс доогуур байдгаас бонд худалдан авалт Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар эрх олгогдсон хэмжээнд хүрээгүй байна.

1.118 НДС-ийн мөнгөн хөрөнгийн удирдлагаар 2012-2018 онд олсон нийт орлогын 72.9 хувийг хадгаламжийн хүүгийн, 16.3 хувийг харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн, 10.8 хувийг Засгийн газрын үнэт цаасны бондын хүүгийн орлогоор бүрдүүлсэн байна.

Хүснэгт 30. НДС-гийн чөлөөт үлдэгдлээс олсон хүүгийн орлогын судалгаа

(сая төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ		Хадгаламж, харилцах, бондын хүүгийн орлого, оноор						Нийт орлого (2012-2018)	
		2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он		2018* он
1.Хадгаламжийн хүүгийн орлого									
Голомт банк		2,685.3	3,069.6	3,076.8	3,590.3	4,616.4	7,510.0	2,425.5	26,974.0
Капитал банк		665.5	5,905.4	17,732.6	21,264.5	16,515.7	24,659.8	10,469.6	97,213.2
УБ хотын банк		1,016.6	3,427.5	10,075.1	14,349.7	12,620.2	23,917.0	14,354.9	79,761.0
Үндэсний хөрөнгө оруулалтын банк		57.5	-	906.3	1,312.2	2,775.9	6,987.0	4,567.7	16,606.7
ХААН банк		409.5	2,044.9	1,230.0	1,004.2	577.9	1,655.9	3,885.8	10,808.2
Хадгаламжийн банк		2,736.2	4,124.2	-	-	-	-	-	6,860.4
Төрийн банк			2,411.4	7,439.9	8,369.8	5,495.0	3,866.8	1,772.9	29,355.7
Хас банк		265.0	-	-	-	-	-	-	265.0
Худалдаа хөгжлийн банк		514.8	2,075.5	-	-	2,162.0	7,443.8	6,383.2	18,579.3
Чингис хаан банк		521.9	1,853.6	4,345.3	4,759.5	4,716.9	10,530.9	9,120.6	35,848.6
Капитрон банк			523.1	751.2	1,472.7	1,962.5	3,541.2	2,341.3	10,592.1
Тээвэр хөгжлийн банк		-	-	-	-	-	-	1,322.3	1,322.3
Хадгаламжийн хүүгийн орлогын дүн		8,872.4	25,435.3	45,557.1	56,123.0	51,442.5	90,112.5	56,643.8	334,186.6
2. Харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого		9,292.7	10,013.5	13,539.6	6,692.8	7,550.2	12,020.2	15,633.3	74,742.3
3. Бондын хүүгийн орлого		3,275.9	12,935.7	-	10,760.9	13,321.4	6,840.0	2,322.0	49,455.9
НИЙТ		21,441.1	48,384.5	59,096.6	73,576.7	72,314.1	108,972.7	74,599.1	458,384.8
Үүнээс	НДС-ийн	12,502.4	30,688.9	36,229.4	41,334.5	40,520.1	63,357.7	73,541.8	298,174.6



ЭМДС-ийн	8,938.7	17,695.7	22,867.2	32,242.2	31,794.0	45,615.0	1,057.3	160,210.2
Сангийн чөлөөт үлдэгдэл	411,662.5	816,127.5	809,105.5	699,910.6	872,603.9	1,097,016.4	947,952.1	-
Ашгийн хувь	5.2	5.9	7.3	10.5	8.3	9.9	7.9	-

Эх сурвалж: НДЕГ

*2018 оны хүүгийн орлогын дүнд ЭМДС-гийн чөлөөт үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого ороогүй болно.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн хүүгээс олох боломжит орлого болох 4.9 тэрбум төгрөгийг тэтгэврийн зээлийн хүүг бууруулахад зарцуулсан байна

1.119 НДҮЗ-ийн 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-ын 3.2-т “Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилгоор банкнуудад нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс зээлийн эх үүсвэр болгон байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг тэтгэврийн зээлийн хүү болон тухайн банкны маржины зөрүүгээр тогтооно” гэж заасан байна.

1.120 Энэ хүрээнд НДС-гийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банканд хадгаламж хэлбэрээр 277.3 тэрбум төгрөгийг 2017 оны 01 дүгээр сараас 2019 оны 09 дүгээр сарыг дуусах хүртэл хугацаанд хүүгийн түвшинг Монголбанкны бодлогын хүүгээс 1.0-4.0 пунктээр бууруулж байршуулснаас хүүгээс олох боломжит орлого болох 4.9 тэрбум төгрөгийг тэтгэврийн зээлийн хүүг бууруулахад зарцуулсан байна.

1.121 Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.24-т “Тэтгэврийн зөрүүг ойртуулах, зээлийн хүүг бууруулах бодлого баримтална” гэж заасны дагуу НДС-гийн чөлөөт үлдэгдлээс тэтгэврийн зээлийн хүүг бууруулах арга хэмжээг авсан байна. Гэвч НДС-гийн хөрөнгөөр тэтгэврийн зээлийн хүүг бууруулсан нь сангийн үйл ажиллагаанд хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан гэж үзэхээр байна.

1.122 Энэ нь Арилжааны банкуудыг дэмжсэн үйл ажиллагаа гэж үзэж болохоор байгаа бөгөөд НДС-гийн орлого буурах, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах үр нөлөөтэй байна.

1.123 НДС-гийн чөлөөт үлдэгдлийг удирдахдаа Засгийн газрын бонд худалдаж авах, арилжааны банканд хөрөнгө хадгалуулж өсгөхөөс гадна олон улсын сайн жишигт нийцүүлэн эрсдэлгүй, үр ашигтай удирдах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.



БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРХ ЗҮЙН ОРЧИН ЗӨРЧИГДӨЖ, ҮР ДҮНГҮЙ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

Төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс төсөвт өртөг нэмэгдэж, хэрэгжилт удааширсан байна

2.1 НДС-гийн 2012-2016 оны Төсвийн тухай хуульд ХАХНХС-ын (хуучин нэрээр) багцад батлагдсан 58.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 171 төсөл, арга хэмжээнд 32.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 31. НДС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний судалгаа

(сая төгрөг)


НДС-гийн ТТХ	Барилга, өргөтгөл			Их засвар			Тоног төхөөрөмж			ТЗЗҮ		
	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Санхүүжсэн дүн	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Санхүүжсэн дүн	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Санхүүжсэн дүн	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Санхүүжсэн дүн
2012 он	4,731.6	2	565.4	381.4	9	378.2	862.6	8	856.2	-	-	-
2013 он	5,298.8	5	3,290.0	831.3	14	734.5	1,260.6	6	1,155.8	83.8	1	59.6
2014 он	14,271.2	13	6,448.0	873.1	11	839.7	11,808.0	6	1,999.3	-	-	-
2015 он	10,465.2	15	8,339.5	1,070.5	16	1,031.4	3,222.9	6	3,070.4	366.2	1	362.6
2016 он	-	-	-	1,042.7	10	1,005.5	1,845.3	44	1,836.6	115.1	4	72.8
Нийт	34,766.8	35	18,642.9	4,199.0	60	3,989.3	18,999.4	70	8,918.3	565.1	6	495.0

Эх сурвалж: НДЕГ

2.2 НДС-гийн 2012-2016 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 48.6-97.6 хувьтай байна. Батлагдсан хөрөнгийн зардлыг 100 хувь ашиглаж чадаагүй нь зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, газрын зөвшөөрөл болон техникийн нөхцөл олгогдоогүй зэргээс шалтгаалсан байна.

График 8. НДС-гийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөг)



Эх сурвалж: НДЕГ

2.3 ХАХНХС (хуучин нэрээр) Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹¹-т заасныг хэрэгжүүлээгүйгээс Нийгмийн даатгалын сангийн 2012-2016 оны Төсвийн тухай хуульд зураг, төсөвтэй байх шаардлагатай 23 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 1 нь хуульд тусгагдахын өмнө төсөвлөлтийн шаардлага хангаж зураг, төсвөө батлуулсан, 15 нь хуульд тусгасны дараа зураг, төсвийг батлуулсан, 7 нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй байна.

Хүснэгт 32. 2012-2016 онд шинээр эхлүүлсэн ТАХ-ний зураг төсвийг баталгаажуулсан байдал

Д/д	НДС-гийн ТТХ	Шинээр эхлүүлэхэд зураг, төсөв шаардлагатай ТАХ-ний тоо	Үүнээс:					
			Хуульд тусгахын өмнө зураг, төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Хуульд тусгасны дараа зураг, төсвийг нь батлуулсан ТАХ-ний		Зураг, төсвийг нь батлуулаагүй ТАХ-ний	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	2012 он	2	-	-	2	8.7	-	-
2	2013 он	4	-	-	3	13.1	1	4.3
3	2014 он	9	1	4.3	2	8.7	6	26.1
4	2015 он	8	-	-	8	34.8	-	-

¹¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



5	2016 он	-	-	-	-	-	-
	Нийт	23	1	4.3	15	65.3	30.4

Эх сурвалж: НДЕГ

2.4 НДС-гийн 2012-2013 оны Төсвийн тухай хуульд ТЕЗ-ийн багцад батлагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 68.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тухайлбал,

Нийгмийн даатгалын сангийн 2012 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй

- Чингэлтэй дүүргийн НДХ-ийн конторын хуучин барилгад - 45.4 сая төгрөг;
- Дорнод аймгийн НДХ-ийн засварт – 5.2 сая төгрөг.

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй

- Сонгинохайрхан дүүргийн НДХ-ийн их завсарт – 18.0 сая төгрөг тус тус олгосон байна.

2.5 НДС-гийн 2014 оны төсвийн тухай хуульд 139.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй НДХ-ийн барилгын өргөтгөл /Баян-Өлгий, Өлгий сум/, 27.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дүүргийн НДХ-ийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Багахангай дүүрэг/ төсөл, арга хэмжээний ангиллыг өөрчилж, хууль зөрчин зах зээлийн үнэлгээ хийгдээгүй барилгыг худалдаж авсан байна.

Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад үндэслээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, үр ашиггүй зардал гаргасан байна

2.6 ХАХНХС (хуучин нэрээр) орон нутагт хэрэгцээ, шаардлагагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж НДС-гийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Тухайлбал,


- Нийгмийн даатгалын сангийн 2015 оны Төсвийн тухай хуульд 820.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийгмийн даатгалын тасгийн барилга /Архангай, Хайрхан сум/ төсөл, арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлэхдээ орон нутгаас санал, хүсэлт аваагүй, тус сумын хүн амын тоо 3.7 мянга байхад 252.0 м² талбайтай үүнээс ашигтай талбай нь 140.0 м² хоёр давхар, таван өрөө, машины гарааштай барилгыг барихаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Одоогийн байдлаар тус барилгын 1 өрөө, 59.9 м² талбай болон авто машины гарааш ашиглалтгүй, ашиглалтад орсноос 2018 оныг дуусах хүртэл хугацаанд 28.5 сая төгрөгийн ашиглалтын зардал гарсан байна;
- Нийгмийн даатгалын сангийн 2015 оны Төсвийн тухай хуульд 820.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийгмийн даатгалын тасгийн барилга /Сэлэнгэ, Алтанбулаг сум/ төсөл, арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлэхдээ хэрэгцээ, шаардлагад үндэслээгүй тус сумын хүн амын тоо 4.7 мянга байхад 252.0 м² талбайтай хоёр давхар, долоон өрөө барилгыг барихаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Одоогийн байдлаар тус барилгын 4 өрөө, 209.0 м² талбай ашиглалтгүй, ашиглалтад орсноос 2018 оныг дуусах хүртэл хугацаанд 9.7 сая төгрөгийн ашиглалтын зардал гарсан байна;
- Нийгмийн даатгалын сангийн 2011 оны Төсвийн тухай хуульд 292.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийгмийн даатгалын тасгийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/ төсөл, арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлэхдээ хэрэгцээ, шаардлагад үндэслээгүй тус сумын хүн амын тоо 25.7 мянга байхад 323.7 м² талбайтай хоёр давхар, арван өрөө барилгыг барихаар төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Одоогийн байдлаар тус барилгын 4 өрөө, 161.8 м² талбай ашиглалтгүй, ашиглалтад орсноос 2018 оныг дуусах хүртэл хугацаанд 55.3 сая төгрөгийн ашиглалтын зардал гарсан байна.

2.7 Цаашид дээрх барилгуудын ашиглалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.



Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох “Үнэлгээний хороо”-г байгуулахдаа ил тод байдлыг хангах зарчмыг баримтлаагүй байна

График 9. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт



2.8 Нийгмийн даатгалын сангийн 2012-2016 оны Төсвийн тухай хуулиар ХАХНХС-ын (хуучин нэрээр) багцад батлагдсан 151 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 40 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 46 хувийг харьцуулалтын аргаар, 9 хувийг шууд гэрээ байгуулах аргаар, 5 хувийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг сонгосон байна.

2.9 НДЕГ-ын даргын тушаалаар 2012-2015 онд 12 удаа худалдан авах ажиллагааг зохион байгуулах “Үнэлгээний хороо”-г байгуулахдаа төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн хөндлөнгийн төлөөлөл оролцуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 4¹² дэх хэсгийг зөрчиж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаагүй байна.

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудад орон сууцны мөнгөн тэтгэлэг олгох журамд заасан шаардлагыг зөрчиж, нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж байгаагүй хүмүүст тэтгэлэг олгосон байна

2.10 Нийгмийн даатгалын албыг мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5-д заасны дагуу НДҮЗ-ын 2010 оны 06 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудыг орон сууцаар хангах, нөхцөл сайжруулах мөнгөн тэтгэлэг олгох журам”-ыг баталж, 2013 оны 19 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудад орон сууцны мөнгөн тэтгэлэг олгох журам”-ыг шинэчлэн баталжээ.

2.11 Аудитын хамрах хүрээний 2012-2015 онд нийгмийн даатгалын байгууллагын 110 ажилтанд 650.8 сая төгрөгийн орон сууцны мөнгөн тэтгэлэг олгосон бөгөөд дээрх журмуудыг шалгуур болгон үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ.

2.12 Нийгмийн даатгалын байгууллагын 4 ажилтанд 21.8 сая төгрөгийн тэтгэлэг олгосон боловч “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудыг орон сууцаар хангах, нөхцөл сайжруулах мөнгөн тэтгэлэг олгох журам”-ын 2.1.5-д “тэтгэлэг авснаас хойш 3-5 жил нийгмийн даатгалын байгууллагад ажиллах талаар үүрэг хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй. Тухайлбал,

- Говь-Сүмбэр аймгийн НДХ-ийн даргаар ажиллаж байсан Д.Гансүхэд 2012 оны Б/286 дугаар тушаалаар 3.8 сая төгрөгийн орон сууцны нөхцөл сайжруулсан тэтгэлэг олгосон боловч 2012 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ажлаас чөлөөлөгдсөн;
- Сүхбаатар аймгийн НДХ-ийн сумын байцаагч Ю.Цэцэгмаа 2014 оны Б/129 тоот тушаалаар 6.0 төгрөгийн орон сууцны тэтгэлэг авсан боловч 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр ажлаас чөлөөлөгдсөн;
- Сэлэнгэ аймгийн НДХ-ийн байцаагч Я.Мөрөн 2014 оны Б/124 тоот тушаалаар 6.0 сая төгрөгийн орон сууцны тэтгэлэг авсан боловч 2015 оны 01 дүгээр сард ажлаас чөлөөлөгдсөн;
- НДЕГ-ын даргын 2014 оны Б/125 дугаар тушаалаар тус бүр 6.0 сая төгрөгийн орон сууцны тэтгэлэг авсан ч Төв аймгийн Сэргэлэн сумын байцаагч А.Мандах 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр ажлаас чөлөөлөгдсөн.

¹² Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгчийг оролцуулна.



2.13 НДҮЗ-ийн 2013 оны 19 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудад орон сууцны мөнгөн тэтгэлэг олгох журам”-ын 2.1.3-д “ажилтан өөрөө орон сууцны мөнгөн тэтгэлэгт хамрагдахыг хүсэж өргөдөл гаргаж, ажилласан жилээр нь өргөдлийн дараалалд бүртгэсэн байх” гэж заасныг зөрчин 2 албан хаагчид 12.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэлэг олгосон.

- Архангай аймгийн НДХ-ийн даргаар ажиллаж байсан Б.Батцэцэг 2013 оны 06 дугаар сард ажилд орж, НДЕГ-ын даргын 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Б/414 дүгээр тушаалаар 6.0 сая төгрөгийн орон сууцны тэтгэлэг олгохоор шийдвэрлэсэн;
- Хэнтий аймгийн НДХ-ийн даргаар ажиллаж байсан Д.Өнөрцэцэг 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ажилд томилогдсон боловч НДЕГ-ын даргын 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Б/437 дугаар тушаалаар 6.0 сая төгрөгийн орон сууцны тэтгэлэг олгохоор шийдвэрлэсэн.


2.14 Нийгмийн даатгалын албыг мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, урамшуулах зорилгоор батлагдсан журмыг зөрчин энэ байгууллагад ажилладаггүй 3 хүнд нийт 18.0 сая төгрөгийн орон сууцны нөхцөл сайжруулах мөнгөн тэтгэлэг олгосон байна.

- НДЕГ-ын даргын 2013 оны Б/368 дугаар “Орон сууцны нөхцөл сайжруулах мөнгөн тэтгэлэг олгох тухай” тушаалаар Баянгол дүүргийн НДХ-ийн байцаагч Э.Энхзаяа 6.0 сая төгрөгийн тэтгэлэг олгосон гэх боловч Э.Энхзаяа нь ажиллаж байсан нь нотлогдохгүй байна.
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн даатгалын албаны дарга О.Золзаяа НДЕГ-ын даргын 2014 оны Б/30 дугаар тушаалаар 6.0 сая төгрөг, Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын ЭМД-ын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Ренчинхандад 2014 оны Б/128 дугаар тушаалаар 6.0 сая төгрөг тус тус олгосон байна.

Сангуудад он дамжсан нийт 116.6 тэрбум төгрөгийн авлага үүссэн байна

2.15 НДШ-ийн авлага 2012 онд 19.6 тэрбум төгрөг байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 116.6 тэрбум төгрөг болж, 97.0 тэрбум төгрөгөөр буюу 6 дахин өссөн байна. НДС-гийн орлогод эзлэх шимтгэлийн авлагын хэмжээ 2018 оны байдлаар 5.6 хувьд хүрчээ.

График 10. НДС-гийн орлогод эзлэх шимтгэлийн авлагын хэмжээ, хувиар




Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

2.16 НДШ-ийн авлагад 2018 оны эцсийн байдлаар шүүхийн шийдвэр гарсан 472 ААН, байгууллагын 6,498.8 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь нийт авлагын 5.6 хувийг эзэлж байна.



График 11. НДШ-ийн авлагын үлдэгдэлд эзлэх шүүхийн шийдвэртэй авлагын хэмжээ, хувиар



Эх сурвалж: Аудитын багийн тооцоолол

2.17 НДШ-ийн 2018 оны нийт авлагын 101.5 тэрбум төгрөг буюу 87 хувь нь ААНБ-аас авах авлага, 1.6 тэрбум төгрөг буюу 1.4 хувь нь төсвийн байгууллагаас авах авлага, 13.5 тэрбум төгрөг буюу 11.6 хувь нь төрийн өмчит байгууллагуудын авлага тус тус эзэлж байна.

2.18 НДЕГ-аас 2012-2018 онд шимтгэлийн авлага барагдуулах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- НДЕГ-ын даргын зөвлөлөөр баталсан хуваарийн дагуу Ховд аймаг, Чингэлтэй дүүргийн өртэй ААН-үүдэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Тухайлбал, Ховд аймагт үйл ажиллагаа явуулдаг “Алтайн зам” ХХК-ийн 2014 оны 663.4 сая төгрөгийн НДШ-ийн өглөгийг барагдуулж, 78.0 сая төгрөгийн алданги тооцож төлүүлсэн. Мөн Чингэлтэй дүүргийн НДШ-ийн өртэй 8 ААН-ын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж 55.0 сая төгрөгийн өр төлбөр, нийт 718.4 сая төгрөгийн өр төлбөр барагдуулан ажилласан байна;
- ННДГ-тай хамтран 2015 онд НДШ-ийн өртэй нийт 61 ААН-тэй өр, авлага барагдуулах талаар гэрээ байгуулж, 16 байгууллагын НДШ-ийн өрийг бүрэн барагдуулж, аймаг дүүргүүдийн холбогдох ажилтнуудтай хамтран нийт 112 ААН-ийн дансыг хааж НДШ-ийн өрийг барагдуулах талаар ажилласан;
- НДШ-ийн авлагыг бууруулах зорилгоор “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” ЭМНДЕГ-ын даргын 2016 оны 01 дүгээр албан даалгавар гаргаж, албан даалгаврын хүрээнд оны эхний авлагаас 39.8 тэрбум төгрөг, нийт 66.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн;
- НДШ-ийн авлагын 2017 оны эхний үлдэгдэл 104.1 тэрбум төгрөгийн НДШ-ийн хуримтлагдсан авлагаас 19,620 ААН-ийн 63.3 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулан, эхний үлдэгдлийг 60.8 хувиар бууруулсан. Мөн тайлант онд үүссэн авлагаас 4,478 ААН-ийн 71.5 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан нь тайлант хугацаанд үүссэн авлагыг 53.3 хувиар бууруулжээ. НДШ-ийн авлага барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам” боловсруулж 2017 оны А/108 тоот тушаалаар батлуулан хэрэгжүүлж, авлага барагдуулах хуваарь гарган 7.3 тэрбум төгрөг, улсын байцаагчийн акт, албан шаардлагаар 9.2 тэрбум төгрөг, харилцах дансны гүйлгээг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авснаар 6.2 тэрбум төгрөг, шүүхэд нэхэмжлэх гаргаж 5.3 тэрбум төгрөгийн авлага тус тус барагдуулсан;
- НДШ-ийн өртэй үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААНБ-дад итгэл хүлээлгэж, үүссэн шимтгэлийн төлбөрийг төлүүлэх хуваарь гарган баталгаажуулж, хариуцах дансны зарлагын гүйлгээ хийх эрхийг нь нээж, шүүхийн шатанд шилжүүлэх үйл ажиллагааг түр хугацаагаар хойшлуулах арга хэмжээ авсан;
- НДЕГ-ын даргын 2018 оны А/173 тоот тушаалаар “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг эрчимжүүлэх” ажлын хэсэг байгуулан ажлын төлөвлөгөө гарган, НДШ-ийн авлага барагдуулахтай холбоотой нийт 18 байгууллагатай хамтран ажиллаж байна;

2.19 НДЕГ-ын 2018 оны А/22 дугаар тушаалаар Санхүү бүртгэлийн газарт Хуримтлалын сан, өрийн удирдлагын хэлтэс шинээр байгуулагдсан нь Нийгмийн даатгалын хууль тогтоомж, НДС-гийн өрийн удирдлагыг хэрэгжүүлэх, НДС-гийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж, нэмэгдүүлэн хуримтлал бий болгох ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.



2.20 НДЕГ-аас ажил олгогчтой уулзалт зохион байгуулахад НДШ-ийн авлагыг эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, төсөвт байгууллагын санхүүжилт удааширдаг зэрэг шалтгаанаас үүсдэг гэх боловч тусгайлан судалгаа хийж, авлага үүсэж буй суурь шалтгааныг тодорхойлж ажиллаагүйгээс тодорхой үр дүнд хүрээгүй байна.

2.21 НДҮЗ-ийн 2013 оны 16 дугаар тогтоолоор 373 ажил олгогчтой холбоотой 4.7 тэрбум төгрөгийн НДШ-ийн авлагыг найдваргүйд тооцож, данснаас хасаж, үүссэн хохирлыг хэмжээг НДС-гийн орлогын эх үүсвэрээр хаасан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага нэмэгдэж, даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авч чадахгүй байх эрсдэл үүсэж байна

2.22 НДШ-ийн авлагыг хэрхэн шийдвэрлэх талаар хуулийн нарийвчилсан зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 17, 19 дэх хэсэгт заасны дагуу хариуцлагын талаарх харилцааг зохицуулж байна.

2.23 НДҮЗ-ийн 2018 оны 07 дугаар тогтоолоор “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ыг баталсан боловч Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус журмыг батлах тусгайлсан эрх НДҮЗ-д олгогдоогүй учир хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

2.24 Нийт 45892 ААНБ-аас авах НДШ-ийн авлагыг 2018 оны жилийн эцсийн байдлаар авч үзвэл 19.3 тэрбум төгрөг буюу 16.5 хувийг уул, уурхайн салбар, 17.0 тэрбум төгрөг буюу 14.6 хувийг барилгын салбар, 80.3 тэрбум төгрөг буюу 68.9 хувийг бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ эзэлж байна.

Хүснэгт 33. НДС-д бүртгэлтэй авлагын үлдэгдэл


Ангилал	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Аж ахуй нэгж	16.1	18.8	34.4	66.6	90.5	94.1	101.5
Төсвийн байгууллага	0.5	0.7	0.5	2.8	1.4	1.5	1.6
Төрийн өмчит байгууллага	3.0	5.0	6.8	13.2	11.9	14.2	13.5
Сайн дурын даатгуулагч	0.01	0.01	0.01	0.01	0.02	0.02	0.004
Нийт авлага	19.6	24.4	41.8	82.5	103.9	109.8	116.6

Эх сурвалж: НДЕГ

2.25 Авлагын 2018 оны үлдэгдлийг 2012 онтой харьцуулахад 5.9 дахин өссөн байна.

2.26 Нийгмийн даатгалын байгууллагын 2018 оны жилийн эцсийн байдлаарх нийт 45892 ААНБ-аас авах авлагыг хэмжээгээр нь авч үзвэл хамгийн их нь 4.4 тэрбум, хамгийн бага нь 0.1 төгрөг байна.

График 12. НДШ-ийн өглөгтэй байгууллагын тоо, тэрбум төгрөг



Эх сурвалж: УАГ

2.27 Нийгмийн даатгалын байгууллага улсын хэмжээнд 2018 оны байдлаар 21897 ААНБ-аас 116.6 тэрбум төгрөгийн НДШ-ийн авлагатай байна.



Хүснэгт 34. Шимтгэлийн авлагын насжилт

(тэрбум төгрөг)

Насжилт /хоног/	Авлагын хэмжээ						
	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
0-30	5.1	5.6	9.1	15.5	15.6	20.6	21.0
31-60	2.8	3.6	5.8	10.2	10.1	10.4	12.0
61-90	2.9	3.2	5.7	9.9	9.4	7.9	10.3
91-120	0.6	1.1	2.1	4.7	6.6	5.6	6.2
120-дээш	8.2	11.0	19.1	42.2	62.1	65.3	67.1
НИЙТ	19.6	24.4	41.8	82.5	103.9	109.8	116.6

Эх сурвалж: НДЕГ

2.28 НДШ-ийн авлагыг насжилтаар нь ангилбал 2018 оны нийт авлагын 67.1 тэрбум төгрөг буюу 57.5 хувийг хуримтлагдсан авлага, 6.2 тэрбум төгрөг буюу 5.3 хувийг 91-120 хоногтой авлага, 10.3 тэрбум төгрөг буюу 8.9 хувийг 61-90 хоногтой авлага, 12.0 тэрбум төгрөг буюу 10.3 хувийг 31-60 хоногтой авлага, 21.0 тэрбум төгрөг буюу 18 хувийг 0-30 хоногтой авлага тус тус эзэлж байна.

2.29 Монгол Улсын Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2006 оны 18/03 дугаар хамтарсан тушаалаар баталсан Нийгмийн даатгалын системийн хэмжээнд дагаж мөрдөх “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 1.4-т “Ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын сангуудад төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоогоор үүссэн авлагыг сан тус бүрээр ангилан НДШ-ийн тооцооны авлага дансанд шууд бүртгэнэ. ...” гэж заасны дагуу бүртгэж, тайлагнаж байна.

2.30 Ажил олгогч НДШ-ийн өглөгтэй байгаа нь НДС-гийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгоход хүндрэл учруулахаас гадна тухайн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагчдын нийгмийн баталгаа алдагдаж, НДС-гаас үйлчилгээ авах эрх нь хязгаалагдах эрсдэл үүсгэж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар хяналт, шалгалтыг тогтмол хийдэг боловч зөрчил давтагдан гарч, үр нөлөө багатай байна

2.31 НДЕГ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”, 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн дагуу нийгмийн даатгалын хяналт шалгалтыг харьяа нэгжүүдийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна.

2.32 НДЕГ-ын даргын 2010 оны 107, 2018 оны А/186 дугаар тушаалаар орон нутаг дахь нийгмийн даатгалын газар, хэлтэс, тасгуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 жил тутамд, төлөвлөгөөт хяналт шалгалтаас бусад төрлийн гүйцэтгэлийн хяналт шалгалтыг тогтмол, тухай бүр нь зохион байгуулахаар баталж, хэрэгжилтийг хангуулсан байна.

2.33 ХНХС-ын 2016 оны “Аян зохион байгуулах тухай” А/319, НДЕГ-ын даргын 2017 оны “Аян зохион байгуулах тухай” А/11 дүгээр тушаалаар “Тэтгэвэр тогтоолт, олголтыг шалгах аян”-ыг улс орон даяар зохион байгуулж, шинээр тэтгэвэр тогтоолтын 46245, хуучин тогтоолтын 33371, тэтгэвэр олголтын 540469 хувийн хэргийг дахин хянаж, шалгасан байна. Тус шалгалтаар 303 тэтгэвэр авагчид дутуу олгосон 81.6 сая төгрөг, 265 тэтгэвэр авагчид илүү олгосон 213.5 сая төгрөг, нийт 568 тэтгэвэр авагчтай холбоотой 295.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, бүрэн барагдуулсан байна.

2.34 Орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудын тэтгэврийн даатгалын санд 2012-2018 онд улсын байцаагчийн актаар 7.0 тэрбум төгрөгийн төлбөр тогтоогдсон бөгөөд барагдуулалт 85.7 хувьтай байна. Үүнээс 4.6 тэрбум төгрөг буюу 65.7 хувь нь тэтгэвэр тогтооллогчийн буруугаас, 2.4 тэрбум төгрөг буюу 34.3 хувь нь улсын байцаагчийн буруугаас үүссэн байна. Мөн төлбөрийн актын 6.4 тэрбум төгрөг буюу 91.4 хувь нь тэтгэврийг илүү



тогтоосон, 0.6 тэрбум төгрөг буюу 8.6 хувь нь тэтгэврийг дутуу тогтоосон зөрчилд хамаарч байна.

2.35 Дээрхээс дүгнэхэд хяналт, шалгалт тогтмол хийж, зөрчлийг илрүүлж, арилгах арга хэмжээ авдаг хэдий ч зөрчлүүд нь байнга дахин давтагдаж байгаа нь дотоод хяналт үр нөлөө багатай байгаа төдийгүй дахин зөрчил гаргуулахгүй байх бодлогын шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт бүрэн хэрэгжихгүй байна

2.36 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд эрүүл мэндийн даатгалын байгууллага дотоод хяналтын нэгжтэй байхаар зааж, дүрмийг нь Нийгмийн даатгалын байгууллага батлахаар хуульчилсан байна.

2.37 Гэвч ЭМДЕГ-т бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулах дотоод хяналтын нэгжийг өнөөг хүртэл байгуулаагүй байна.

2.38 ЭМДҮЗ-ийн ажлын албаны дүрмийн 3.2.5-д ЭМДҮЗ-ийн ажлын алба ЭМД-ын сангийн болон үйл ажиллагааны зардлын төсвийн гүйцэтгэлийн тайланд эдийн засгийн шинжилгээ, судалгаа хийх үүрэг хүлээсэн боловч ажлын албаны үйл ажиллагаа нь жигдрээгүй, хүний нөөцийн хүрэлцээгүй байдал зэргээс шалтгаалан энэхүү чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл нь хуульд заасан хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна

2.39 Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3.3-т “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих” эрхийг НДҮЗ-д олгосон байна.

2.40 Аудитад хамрагдсан 2012-2018 онд НДҮЗ болон ажлын албаны даргын тушаалаар баталсан удирдамж, чиглэлийн дагуу ажлын албанаас 3 удаагийн хяналт шалгалтыг хийсэн боловч үр дүнг нэгтгэж дүгнээгүй, түүний мөрөөр авсан арга хэмжээ байхгүй байна. Тухайлбал,

- НДҮЗ-ийн ажлын алба Баянзүрх, Чингэлтэй дүүргийн НДХ-т 2012 оны 04 дүгээр сарын 09-12-ны өдөр Нийгмийн даатгал, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, сангийн орлого зарлагын байдалд хяналт тавих, ЭМД-ын санхүүжилтийн талаар шалгах дотоод хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж өгөхөөр ажилласан байна. Энэ шалгалтын үр дүнг нэгтгэж дүгнэсэн, түүний мөрөөр авсан арга хэмжээ байхгүй байна.
- Тайлан зөвлөмж хүргүүлэх тухай 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 201 дугаартай албан бичигт хангайн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган аймгийн НДХ, ННДГ болон Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн НДХ нийт 11 байгууллагын үйл ажиллагаатай танилцах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлыг 2016 оны 06 дугаар сарын 06-15-ны өдөр зохион байгуулж, ЭМНДЕГ-т 6 зөвлөмж, аймаг дүүргийн НДХ-үүдэд 8 зөвлөмж өгсөн байна. Тус тайлан зөвлөмж хүргүүлэх албан бичигт дурдагдсан 11 байгууллагын Дархан-Уул аймгаас бусад газар, хэлтэст хийсэн шалгалт нь удирдамж, чиглэл байхгүй цөөхөн хоногт олон байгууллагыг хамруулсан хэдий ч бүх хэлтэс газруудад өгсөн зөвлөмж нь ямар дүгнэлтэд үндэслэж өгсөн нь тодорхойгүй байна.
- НДҮЗ-ийн ажлын албаны даргын 2017 оны “Томилолтоор ажиллуулах тухай” А/24 дүгээр тушаалаар 2017 оны 12 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн ЭМНДХ-ийн үйл ажиллагаатай танилцах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, дотоодын хяналтыг сайжруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар санал солилцох, зөвлөмж өгөхөөр ажилласан байна. Энэ шалгалтын үр дүнг нэгтгэж дүгнэсэн, түүний мөрөөр авсан арга хэмжээ байхгүй байна.



2.41 НДҮЗ-өөс хийсэн хяналт, шалгалтын үр дүн тодорхойгүй, шалгалтын ажлын тайлан, дүгнэлт нь баталгаажаагүй байгаа нь хуульд заасан чиг үүргээ бүхэн хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулж байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар нийгмийн даатгалын сангийн 2014-2018 оны 843.9 тэрбум төгрөгийн алдагдлыг төсөвт тодотгол хийхгүйгээр улсын төсвийн татаас болон сангийн чөлөөт үлдэгдлээс санхүүжүүлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг зөрчсөн байна.
- Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хурлаас 1999 онд тодорхойлсон тэтгэврийн даатгалын санд төвлөрсөн орлогыг зардалд хуваарилах хэлбэрээс хуримтлалын хэлбэрт үе шаттай шилжих, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо (*хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжих*)-г бий болгох бодлогын зорилго, зарчимд нийцүүлсэн эрх зүйн орчныг бүрдүүлээгүйгээс даатгуулагчид шударгаар үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна.
- Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийн үр нөлөө тухайлбал, Тэтгэврийн даатгалын санд 1995 оноос хойш тэтгэврээ тогтоолгосон иргэний 1995 оноос өмнөх хугацаанд ажилласан жилд ногдох тэтгэврийн зардлыг хариуцуулж, 1995-2018 оныг дуусах хүртэл хугацаанд ойролцоогоор 4.9 их наяд төгрөгийг зарцуулсан, Улсын Их Хурлаас 2007 онд баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 5 пунктээр бууруулснаас Тэтгэврийн даатгалын санд 1.4 их наяд төгрөгийн орлого төвлөрөх боломж алдагдсан, мөн 2012 онд баталсан Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтээр санд нийт 37.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 2018 оны байдлаар 704.6 тэрбум төгрөгийн зардал гарсан (цаашид зардлын хэмжээ өснө), Засгийн газраас инфляцын түвшинтэй уялдуулж тэтгэврийн хэмжээг удаа дараа нэмдэг ч дараа дараагийн жилүүдийн улсын төсөвт тэрхүү нэмэгдлээ тусгадаггүй бөгөөд 2012-2018 онд тэтгэвэр нэмсэн шийдвэрийн хэрэгжилтээр 2.1 их наяд төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаагаас шалтгаалан тус сан алдагдалд орох нөхцөл бүрдэж, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.2-т заасан сангийн бие даасан байдлыг сайжруулах бодлого хэрэгжихгүй байна.
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд 2017 оны байдлаар 15.4 их наяд төгрөгийн хийсвэр тооцоолол хийгдэж (НДҮЗ-өөс нэрийн дансны шимтгэлийн орлогод тооцох тухайн жилийн хүүгийн дүнг батлаагүйгээс 2018 оны тооцоолол хийгдээгүй), эрх зүйн зохицуулалтгүйгээс шалтгаалан мөнгөжүүлэх асуудал орхигдсон нь даатгуулагч төлсөн шимтгэлээ хуримтлалын зарчмаар өсгөж тэтгэвэртээ бүрэн эгүүлэн авах боломжийг хязгаарлаж байна.
- Улсын хэмжээний нийт ажиллах хүч 1358.6 мянган иргэн байгаагаас 405.9 мянга нь (үүнээс 45.8 хувь буюу 185.9 мянга нь малчин, 54.2 хувь буюу 220.0 мянга нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэн) нийгмийн даатгалын тогтолцооны гадна байгаа бөгөөд тэдгээрт сайн дурын хэлбэрээр даатгуулах сонголт олгосноос нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжихгүй, улмаар эдгээр иргэдийн нийгмийн баталгааг төр хариуцах эрсдэл үүсэж байна.
- Монгол Улсын Засгийн газар тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлж байгаад нас барсан даатгуулагчийн төлсөн шимтгэлийг хэрхэх асуудлаар эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлээгүй нь төлсөн шимтгэлийнхээ үр шимийг шударгаар хүртэх боломжийг хязгаарлаж байна.
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 2012-2018 онд 127.1 мянган хүнд 164.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгож, түүнээс 72 хүнийг мэргэжлийн сургалтад



хамруулсан нь Засгийн газрын 2001 оны 131 дүгээр тогтоолоор ажилгүйдлийн даатгалын сангаас зарцуулах сургалтын зардлын нэг хүнд ногдох дээд хэмжээг 50.0 мянган төгрөгөөр тогтоосон, тухайн зардлаар мэргэшүүлэх сургалт явуулах боломжтой эсэх талаар судалгаа, шинжилгээ хийгээгүй зэргээс ажилгүй болсон даатгуулагчийг мэргэжлийн сургалтад хамруулах хуулийн зорилт хангагдахгүй байна.

- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл болон нийгмийн даатгалын байгууллагын удирдлагаас ил тод байдлыг хангасан шийдвэр гаргах эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, чөлөөт үлдэгдлийг банканд байршуулахдаа Монголбанкны бодлогын хүүгийн хувь хэмжээнээс бага хүүтэй хадгалуулсан нь сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх илүү орлого олох боломжийг алдсан, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан байж болзошгүй байна.
- Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү, үнэт цаас арилжаалснаас олсон орлого” хэлбэрээр эх үүсвэр бүрдүүлэхээр заасан нь сангийн хөрөнгийг эрсдэлгүй, үр ашигтай удирдах найдвартай, бодитой шалгуур болж чадаагүй, тухайлбал Капитал банканд нийгмийн даатгалын 104.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын 136.1 тэрбум, нийт 240.3 тэрбум төгрөгийг хадгалуулснаар сангийн хөрөнгийг алдах эрсдэлд оруулсан байна.
- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын байгууллага тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилгоор сангийн чөлөөт үлдэгдлээс 2017 оны 01 дүгээр сараас 2019 оны 09 дүгээр сарыг дуусах хүртэл хугацаанд Монголбанкны бодлогын хүүгээс 1.0-4.0 пунктээр бага хүүгээр гэрээ байгуулж, хадгалуулсан нь 4.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдагдуулж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар удирдсан байна.
- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл хуульд заасан бүрэн эрхээ (тухайлбал Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоох тогтолцоог боловсронгуй болгох, дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг) хэрэгжүүлээгүйгээс тэтгэвэр, тэтгэмжийг зөрүүтэй тогтоох асуудал жил бүр давтагдан гарч, сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, даатгуулагч хохирох эрсдэл үүсгэж байна.
- Монгол Улсын Засгийн газар төрийн байгууллага хооронд мэдээлэл шуурхай солилцох нэгдсэн программ хангамжийг бүрдүүлээгүйгээс шалтгаалж нас барсан хүнд илүү тэтгэвэр олгох, ажилгүйдлийн тэтгэмжийг ажилласан хугацаатай давхардуулан авах нөхцөл үүссэн байна.
- Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд (хуучин нэрээр) 2012-2016 онд орон нутгийн хэрэгцээ, шаардлага, үр ашгийн тооцоололд үндэслэхгүйгээр Нийгмийн даатгалын сангаас санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргаж ашиглалтгүй хөрөнгө, урсгал зардлыг нэмэгдүүлсэн нь холбогдох хуульд хариуцлагын тогтолцоог бүрдүүлээгүйтэй холбоотой байна.
- Нийгмийн даатгалын санд 2018 оны байдлаар 21897 аж, ахуй нэгж байгууллагын 116.6 тэрбум төгрөгийн авлага үүссэн нь эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, төсөвт байгууллагын санхүүжилт удааширдаг зэргээс шалтгаалж, 405648 даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авч чадахгүй байх эрсдэл үүсгэж байна.



Зөвлөмж:

Аудитаар илрүүлсэн зөрчил, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны анхааралд толилуулах нь:

- Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолд заасны дагуу “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого” хэрэгжих эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- Улсын Их Хурлаас 2012 онд баталсан Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөө, 1995 оноос хойш тэтгэврээ тогтоолгосон иргэний 1995 оноос өмнөх хугацаанд ажилласан жилд ногдох тэтгэврийн зардлыг Тэтгэврийн даатгалын санд хариуцуулсан зэрэг нь тус санг алдагдалд оруулах суурь шалтгаан болсонд анхаарч, бодлого зохицуулалтын холбогдох арга хэмжээ авах;
- Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл Нийгмийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн тулгамдсан асуудал хэвээр байгаад анхаарч, тус зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Нийгмийн даатгалын сангийн Төсвийн тухай хуулиар батлагдсан сан тус бүрийн зарлагын дээд хязгаар давсан тохиолдолд уг эх үүсвэрийг холбогдох хуульд нийцүүлэн санхүүжүүлж байх;
- Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг баталсан Монгол Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолыг Засгийн газар хэрэгжүүлж ажиллах;
- Монгол Улсын Засгийн газраас инфляцын түвшинтэй уялдуулан иргэдийн тэтгэврийн хэмжээг нэмсэнтэй холбогдуулан гарах зардлыг шийдвэр хэрэгжиж эхэлсэн тухайн жилийн улсын төсөвт баталж, тэтгэврийн даатгалын санд нэг удаа олгодог ч түүнээс хойших хугацаанд тус сангаас санхүүжүүлж байгаа нь санг алдагдалд оруулахад нөлөөлж байгаа¹³ тул цаашид гарах зардлын эх үүсвэрийг тодорхой болгож, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Нийгмийн даатгалын тогтолцооны үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төрийн байгууллага хооронд мэдээллийг шуурхай солилцох¹⁴ мэдээлэл технологийн нэгдсэн системийг бий болгох.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга нарт:

- Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансанд хуримтлал үүсгэж мөнгөжүүлэх, хуваарилалтын тогтолцооноос хагас болон бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих, нийгмийн даатгалын сангийн бие даасан байдлыг хангах, нийгмийн даатгалын

¹³ Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 17 хуудаснаас харна уу

¹⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 16 хуудаснаас харна уу



хамрах хүрээг өргөжүүлэх, тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлж байгаад нас барсан даатгуулагчийн төлсөн шимтгэлийг хэрхэх талаар бодлогын арга хэмжээ авч, холбогдох хууль тогтоомжийн төсөлд тусган боловсруулж, Засгийн газарт өргөн мэдүүлэх;

- Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг удирдах үйл ажиллагааг олон улсын сайн жишиг, туршлагад үндэслэн сайжруулж, үр ашигтай, эрсдэлгүй удирдах эрх зүйн тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх саналыг боловсруулж, батлуулах;
- Нийгмийн даатгалын санд үүсэж буй авлагын суурь шалтгааныг тодруулж, авлага үүсгэхгүй байх эрх зүйн тогтолцоог бүрдүүлэн даатгуулагчийн эрх ашгийг хангах;
- Аудитаар илэрсэн зөрчил тухайлбал, тэтгэвэр, тэтгэмжийг илүү дутуу тогтоосон, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд батлагдаагүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, журмын шаардлага хангаагүй ажилтанд орон сууцны дэмжлэг олгосон зэрэг асуудлаар шийдвэр гаргасан албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцож, биелэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2020.01.20 № 1/108
танай 2020.01.08 -ны № 02/37 -т


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
С.БҮРЭНБАТ ТАНАА

Үндэсний аудитын газраас "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн /2012-2018 он/"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгах саналыг Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заасны дагуу хүргүүлж байна.

Хавсралт 4/хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.ЗОРИГТ

515150070



Нийгмийн даатгалын ерөнхий
газрын даргын 2020 оны 01 дүгээр
сарын 20-ны өдрийн 1/108 дугаар
албан бичгийн хавсралт

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИД
НЭМЖ ТУСГАХ САНАЛ, ТАЙЛБАР-1**

Нэг: Аудитын зөвлөмжид нэмж тусгах саналын талаар:

1. Нийгмийн даатгалын эрсдэлийн сан байгуулах: Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг гэнэтийн давагдашгүй хүчин зүйл болон эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр үүсэх нийгмийн даатгалын сангийн алдагдлыг нөхөж, уг сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрсдэлийн сан байгуулах, энэ чиглэлээр хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;

2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс өндөр цалин авч байгаа даатгуулагчийн ажил олгогчоос төлж байгаа шимтгэлийн дүн тэтгэвэр тогтоолгоход нөлөөлөх эрх зүйн зохицуулалтгүй байна.

Иймд хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээнээс дээгүүр цалинтай даатгуулагчийг тэтгэврийн хувийн нэмэлт даатгалд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3. Албан журмын даатгуулагч болон сайн дурын даатгуулагчийн төлөх хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг ялгаатай тогтоох;

Албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөр боловч тэтгэвэр, тэтгэмж тогтоох аргачлал нь ижил байдаг тул тэтгэвэр, тэтгэмж тогтоох хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг ялгаатайгаар тогтоох шаардлагатай байна.

Сангийн яаманд:

1. ХНХС-ын зөвлөлийн хурал, НДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн нийгмийн даатгалын сангийн тухайн жилийн төсвийн төсөл, төсөөллийг Сангийн яамнаас хянахдаа нийгмийн даатгалын сангийн зарлагын дүнг үндэслэлгүй бууруулахгүй байх чиглэл баримтлах, хуулийн нэмэлт, өөрчлөлтэй холбоотой сангийн зардлын өөрчлөлтийг төсвийн тодотголоор зайлшгүй шийдвэрлэдэг байх;

Хоёр: Аудитын зөвлөмжид тусгагдсан мэдээлэлд өгөх тайлбар, саналын талаар:

1.10 Хүснэгт 4-т заасан Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл нь УИХ-аас баталсан Нийгмийн даатгалын сангийн тухайн онуудын төсвийн тухай хуулиар баталсан орлого зарлагын дүн биш бөгөөд улсын төсвөөс олгосон санхүүжилт, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэний болон Цэргийн албан хаагчийн тэтгэврийн зардлын хассан дүн байна. Иймд хүснэгтийн өмнөх тайлбар болон дараах дүгнэлтийн агуулгууд нь тохирохгүй байна.

1.71 ҮОМШӨД Сангийн чөлөөт үлдэгдэл нь жил бүр дунджаар 47.0 хувиар буюу суурь он болох 2012 онтой харьцуулахад 521.7 тэрбум төгрөгөөр буюу 7.0



дахин өссөн байна. Хүснэгт 17-д тухайн жилийн орлого зарлагын зөрүү буюу ашиг /алдагдал/-ыг харуулсан байгаа тул гарчиг болон доторх мэдээлэл нь агуулгын хувьд тохирохгүй байна. Энэхүү ашиг алдагдал нь сангийн чөлөөт үлдэгдэлийг нэмэгдүүлж байгаа болно.

1.81 Ажилгүйдлийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл нь жил бүр дунджаар 7.7 хувиар буюу суурь он 2012 онтой харьцуулахад 48.9 тэрбум төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна. Хүснэгт 20-д тухайн жилийн орлого зарлагын зөрүү буюу ашиг /алдагдал/-ыг харуулсан байгаа тул гарчиг болон доторх мэдээлэл нь агуулгын хувьд тохирохгүй байна. Энэхүү ашиг алдагдал нь сангийн чөлөөт үлдэгдэлийг нэмэгдүүлж байгаа болно.

1.114 2017, 2018 онуудын Мөнгөн хадгаламжийн гэрээний хүүгийн дүн Монголбанкны бодлогын хүүнээс 1-4 хувиар дээгүүр байна.

1.115 Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, тусгагдсан тэтгэврийн зээлийн хүүг үе шаттайгаар бууруулах” зорилт тусгагдсан.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 2018, 2019 онуудад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн тэтгэврийн зээлийн хүү бууруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах үүргийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд өгөгдсөн болно.

2017 онд 6 сарын тэтгэвэртэй тэнцэх хэмжээний тэтгэврийн зээлийн жилийн хүүг жилийн 18 хувь байсныг 3 хувиар бууруулснаар нийт 99163 тэтгэвэр авагчид 79.3 тэрбум төгрөгийн зээлийг сарын 1.25 хувь, жилийн 15.0 хувийн хүүтэйгээр авч, 1,3 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна. Тухайн үед банкуудын маржинг 4.0-4.4 хувиар тооцон, тэтгэврийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт зориулан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгөөс нийт 53.0 тэрбум төгрөгийг 10.6-11.0 хувийн хүүтэйгээр байршуулсан.

2018 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, Төрийн болон ХААН банкууд харилцан ойлголцлын санамж бичиг зурсанаар Монголбанкны ерөнхийлөгчийн 2018 оны А/14 тоот тушаал гарч тэтгэврийн зээлийн хүүг бууруулах зорилгоор банкинд байршуулсан эх үүсвэрээс заавал байлгах нөөцөд байршуулах хувийг чөлөөлсөн.

Энэхүү арга хэмжээний хүрээнд банкуудын маржины хэмжээг өмнөх оноос бууруулан 3 хувиар тогтоож, зээлийн эх үүсвэр болгон байршуулсан 29.0 тэрбум төгрөгийн хадгаламжийн хүүгийн хэмжээг 9 хувиар тогтоон байршуулсан.

2018 онд 12 сар хүртэлх тэтгэврийн 70%-тай тэнцэх хэмжээний зээлийн хүүг 3-6 пунктээр бууруулан, сарын 1 хувь, жилийн 12 хувь болгосноор 53184 тэтгэвэр авагч 52.4 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг хөнгөлөлттэй нөхцлөөр авч, тэтгэвэр авагчид 1.6 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөгдсөн байна. Тэтгэвэр авагчид өмнө нь зээл болон хүүнд тэтгэврээ 100% төлдөг байсан бол 70 хувийг зээл болон хүүнд төлж, 30 хувийг өөрт нь олгосноор сар бүр тогтмол орлоготой байх боломж бүрдсэн.

2019 оны 01 дүгээр сард 12 сар хүртэлх тэтгэврийн 70%-тай тэнцэх хэмжээний зээлийн хүүг 3-8 пунктээр бууруулан, сарын 0.83 хувь, жилийн 10 хувь болгон, 202111 тэтгэвэр авагч 217.1 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг



хөнгөлөлттэй нөхцлөөр авч, 5.0 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлсөн байна. Мөн 10 дугаар сард 13-24 сарын хугацаагаар олгох зээлийн хүүг 12.4 хувиар бууруулан 15.6 хувиар олгосон.

Энэхүү арга хэмжээ нь тэтгэвэр авагчдыг тэтгэврийн зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөх, бага хүүтэй, хөнгөлөлттэй тэтгэврийн зээл авах боломжийг хангасан тэдгээрийг дэмжсэн арга хэмжээ юм. Энэ арга хэмжээнд оролцож байгаа банкууд тэтгэврийн зээл олголтоос зөвхөн маржин буюу үйл ажиллагааны зардлыг авч байгаа тул ашиг олох үйл ажиллагаа биш юм.

Засгийн газраас өгөгдсөн үүргийн дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэн, холбогдох шийдвэрийг гарган, Нийгмийн даатгалын ерөнхий газар хэрэгжүүлэн ажилласан болно.

2.35 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т зааснаар дотоод хяналтын нэгжийн дүрмийг Эрүүл мэндийн даатгалын байгууллага баталж мөрдөхөөр заасан байна.

“Дүгнэлт” хэсэг

1. Хүснэгт 4-т заасны дагуу тухайн жилүүдийн тэтгэврийн даатгалын сангийн алдагдалын нийлбэр дүн 828.4 тэрбум төгрөг байна. Тэтгэврийн даатгалын сан нь 2014-2015 онуудад нь улсын төсвөөс авах санхүүжилтийн авлагатай байсан. 2016-2018 онуудад тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг тухай жилүүдийн Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиар улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгт тусган санхүүжүүлэхээр зардлын төсвийг баталсан байна.

9. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын дагуу мөнгөн хөрөнгийг банкуудад байршуулж байгаа болно.

10. Тэтгэврийн зээлийн хүү бууруулах ажил нь арилжааны банкуудыг дэмжсэн бус тэтгэвэр авагчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тэдгээрийн дэмжин зохион байгуулсан арга хэмжээ юм. 1.115 –т холбогдох тайлбарыг өгсөн болно.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/108
дугаар албан бичгийн хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ТУСГАХ САНАЛ-2 /АЛДААТАЙ ТООН МЭДЭЭЛЛИЙГ ЗАЛРУУЛАХ/

Ерөнхий мэдээлэл Хүснэгт 2. Шимтгэл төлөгч болон үйлчилгээ авагчдын мэдээлэл, тоо

Үзүүлэлт	2017 он	2018 он
ЭМД-ын шимтгэлийг төр хариуцан төлсөн иргэдийн тоо*	1,759,028	1,763,919
НДС-гаас үйлчилгээ авсан даатгуулагч		
Тэтгэвэр	388,562	397,009
Тэтгэмж	194,400	209,571
ҮОМШӨ	9,621	9,185
Ажилгүйдэл	21,163	21,423
ЭМД*	6,860,849	7,317,334

* ЭМДС-гийн 2017 оны НДС-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай тулгасан ба 2018 оны тоо мэдээлэл ЭМДЕГ-аас гарсан тул шалгах боломжгүй байна.
Эх сурвалж дээр ЭМДЕГ-ийг оруулах.

1.6 Хүснэгт 3. Шимтгэл төлөгч болон тэтгэвэр авагчдын судалгаа, тоо

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тэтгэвэр авагчийн тоо	306,844	313,558	344,832	362,174	376,792	393,477	401,660

1. 2012-2016 оны тэтгэвэр авагчдын дүнд ҮОМШӨДС-гаас тэтгэвэр авагчдын дүн ороогүй байна.
2. 1.6 дахь хэсэгт "... тэтгэвэр авсан даатгуулагч 94.8 мянга буюу 31.6 хувиар ..." гэж өөрчлөх

1.10 Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	Мөр	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Орлогын	Төлөвлөгөө	1	446.7	606.0	785.2	750.6	743.8	834.6
	Гүйцэтгэл	2	491.8	634.8	705.3	719.0	767.8	880.3
	Зөрүү	3=(2-1)	45.1	28.8	- 79.9	- 31.6	24.0	45.7
Зарлагын	Төлөвлөгөө	4	451.7	560.7	673.6	857.4	996.5	1,095.4
	Гүйцэтгэл	5	439.1	562.1	749.0	899.3	1,006.5	1,101.9
	Зөрүү	6=(4-5)	- 12.6	1.4	75.4	41.9	10.0	6.5
Алдагдал		7=(2-5)	52.7	72.7	- 43.7	- 180.3	- 238.7	- 221.6
Улсын төсвөөс олгосон санхүүжилт		8	-	-	-	-	181.0	254.8

1.11 "... зарлагын төлөвлөгөө 2013-2017 оны хооронд" гэж залруулах

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

17032 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Утас: 70100005, Факс: 976-70100005

2020.01.16 № А-1/45
танай _____-ны № _____-т

┌ ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ┐

“Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн /2012-2018 он/”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан ба нэмэлт тайлбар, саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯСГАЛАН





ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

ҮАГ-ын тайлбар 1

Аудитын хүрээнд судлагдаагүй асуудал тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.

ҮАГ-ын тайлбар 2

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн зөвлөмжид найруулга хийн тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 3

Аудитын тайлангаар нийгмийн даатгалын тогтолцооны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж өгөгдсөн тул ирүүлсэн саналыг тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ.

ҮАГ-ын тайлбар 4

Саналд ирүүлсэн үндэслэл баримтаар бүрэн нотлогдохгүй байх тул саналыг хүлээж аваагүй.

ҮАГ-ын тайлбар 5

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.10-д хүснэгт 4 -т тайлбар хийн тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 6

Тайлангийн 1.17-д Хүснэгт 17. “ҮОМШӨДС-гийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээлэл”-д аудитын багийн тооцоолол хийгдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 7

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.81-82-ийн гарчигт найруулга хийн тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 8

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.114-т найруулга хийн тусгалаа.

ҮАГ-ын тайлбар 9

Тайлангийн 1.115 дах хэсэгт тэтгэврийн зээлийн хүүг бууруулах нь Нийгмийн даатгалын сангийн харилцааны асуудал биш тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 10

Тайлангийн 2.35-д Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн заалтын дагуу оруулсан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 11



Дүгнэлт 1-д хүснэгт 1-ийн тоон мэдээллээс оруулсан тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 12

Ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.

ҮАГ-ын тайлбар 13

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн алдаатай тоон мэдээллийг залрууллаа.

Эрүүл мэндийн даатгалын газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

ҮАГ-ын тайлбар:

Тайлангийн төсөлтэй танилцсан ба нэмэлт тайлбар, саналгүй болно.

**ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН ХУГАЦААНЫ СУДАЛГАА /2019 оны эхний хагас жилийн байдлаар/**

№	Тэтгэвэр тогтоосон он	Тэтгэврийн төрөл	Нөхцөл	Хүний тоо	Нийт шимтгэл төлсөн сар	1995 оноос өмнө шимтгэл төлсөн		1995 оноос хойш шимтгэл төлсөн	
						сар	хувь	сар	хувь
1	1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон	Өндөр насны	Хэвийн бүрэн	47,876	16,264,029.62	15,274,006.68	93.91	990,022.93	6.09
2			Хэвийн хувь тэнцүү	422	66,768.28	66,318.81	99.33	449.47	0.67
3			Цэргийн бүрэн	2,417	805,624.44	721,347.05	89.54	84,277.38	10.46
4			Цэргийн хувь тэнцүү	68	16,541.55	15,615.16	94.40	926.40	5.60
5		Тахир дутуугийн	Хэвийн бүрэн	2,443	202,279.74	194,936.46	96.37	7,343.28	3.63
6			Хэвийн хувь тэнцүү	181	11,903.17	10,884.13	91.44	1,019.04	8.56
7			Цэргийн бүрэн	83	3,712.33	3,712.20	100.00	0.13	0.00
8			ҮОМШӨ	582	93,867.67	86,430.59	92.08	7,437.08	7.92
9		Тэжээгчээ алдсаны	Хэвийн бүрэн	516	151,066.06	151,066.00	100.00		0.00
10			Хэвийн хувь тэнцүү	19	2,563.89	2,563.86	100.00	-	0.00
11			Цэргийн бүрэн	13	2,988.40	2,988.28	100.00	-	0.00
12			ҮОМШӨ	27	6,458.68	6,458.50	100.00	-	0.00
Дүн				54,647	17,627,803.82	16,536,327.73	93.81	1,091,475.71	6.19
13	1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон	Өндөр насны	Хэвийн бүрэн	234,342	79,124,985.13	50,647,635.55	64.01	28,477,349.58	35.99
14			Хэвийн хувь тэнцүү	20,758	3,523,695.88	2,105,508.42	59.75	1,418,187.48	40.25
15			Цэргийн бүрэн	11,139	3,862,689.31	1,596,978.25	41.34	2,265,711.07	58.66
16			Цэргийн хувь тэнцүү	3,414	685,994.61	398,036.49	58.02	287,958.12	41.98
17		Тахир дутуугийн	Хэвийн бүрэн	20,309	3,617,453.04	1,240,463.97	34.29	2,376,989.07	65.71
18			Хэвийн хувь тэнцүү	44,971	5,047,302.10	2,168,540.48	42.96	2,878,761.64	57.04
19			Цэргийн бүрэн	378	40,326.51	14,159.79	35.11	26,166.72	64.89
20			ҮОМШӨ	3,473	727,829.18	426,679.99	58.62	301,149.19	41.38
21		Тэжээгчээ алдсаны	Хэвийн бүрэн	10,063	2,419,302.39	1,541,559.78	63.72	877,742.61	36.28
22			Хэвийн хувь тэнцүү	9,488	1,128,181.26	672,544.62	59.61	455,636.63	40.39
23			Цэргийн бүрэн	884	178,715.95	81,201.79	45.44	97,514.16	54.56
24			ҮОМШӨ	492	80,392.40	44,386.21	55.21	36,006.20	44.79
Дүн				359,711	100,436,867.77	60,937,695.35	60.67	39,499,172.47	39.33
Нийт дүн				414,358	118,064,671.59	77,474,023.08	65.62	40,590,648.18	34.38



Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсан судалгаа

(сая төгрөг)

ОН	Чөлөөт үлдэгдэл				Нийт	Чөлөөт үлдэгдлийн эх үүсвэр (сангийн төрлөөр)												
	Хадгаламж		Харилцах			Тэтгэвэр		Тэтгэмж		ҮОМШӨ		ЭМД		Ажилгүйдэл		Төвлөрсөн харилцах		
	Дүн	Хувь	Дүн	Хувь		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Голомт банк																		
2012	36,000.0	86.9	5,448.8	13.1	41,448.8	100	2,241.8	5.4	47.3	0.1	7,686.0	18.5	26,042.7	62.8	5,014.7	12.1	416.3	1
2013	20,000.0	64.1	11,185.8	35.9	31,185.8	100	6,784.0	21.8	150.3	0.5	27.3	0.1	20,076.7	64.4	3,429.3	11	718.3	2.3
2014	20,000.0	68.6	9,156.7	31.4	29,156.7	100	4,302.6	14.8	174.6	0.6	582.2	2	22,995.7	78.9	407.4	1.4	694.1	2.4
2015	40,000.0	77.9	11,359.6	22.1	51,359.6	100	7,063.4	13.8	475.8	0.9	10,812.9	21.1	32,496.3	63.3	49.6	0.1	461.5	0.9
2016	50,000.0	68.6	22,887.4	31.4	72,887.4	100	3,072.7	4.2	142.5	0.2	23,745.0	32.6	45,130.5	61.9	68.4	0.1	728.2	1
2017	40,000.0	35	74,419.2	65	114,419.2	100	5,988.1	5.2	735.9	0.6	43,537.3	38.1	63,793.3	55.8	272.8	0.2	91.8	0.1
2018	100,580.0	72.1	38,917.8	27.9	139,497.8	100	11,604.2	8.3	2,540.5	1.8	122,603.2	87.9	1,367.5	1	1,285.2	0.9	97	0.1
2019.06	100,826.5	66.6	50,584.0	33.4	151,410.6	100	25,906.6	17.1	3,153.7	2.1	119,583.9	79	2,138.1	1.4	441.5	0.3	186.7	0.1
Капитал банк																		
2012	26,000.0	82.8	5,409.8	17.2	31,409.8	100	8,272.6	26.3	470.7	1.5	6,358.5	20.2	12,940.5	41.2	3,361.8	10.7	5.6	0
2013	105,000.0	83.1	21,353.2	16.9	126,353.2	100	17,737.3	14	663.6	0.5	32,820.0	26	58,328.7	46.2	16,795.9	13.3	7.7	0
2014	190,000.0	90.7	19,487.3	9.3	209,487.3	100	41,022.9	19.6	2,771.3	1.3	36,896.1	17.6	99,429.5	47.5	29,253.2	14	114.4	0.1
2015	185,000.0	77.7	53,062.0	22.3	238,062.0	100	13,798.1	5.8	4,073.5	1.7	56,607.0	23.8	129,722.2	54.5	33,859.1	14.2	2.1	0
2016	180,000.0	80.3	44,114.6	19.7	224,114.6	100	1,966.4	0.9	1,683.6	0.8	51,459.8	23	135,444.7	60.4	33,388.8	14.9	171.3	0.1
2017	20,000.0	8.8	208,174.5	91.2	228,174.5	100	3,131.3	1.4	2,809.1	1.2	54,262.7	23.8	132,537.7	58.1	35,424.7	15.5	8.9	0
2018	2,400.0	2.3	102,903.6	97.7	105,303.6	100	3,260.8	3.1	2,090.3	2	61,230.0	58.1	36.6	0	38,672.1	36.7	13.7	0
Капитрон банк																		
2012	-	0	7,608.6	100	7,608.6	100	563.7	7.4	552.7	7.3	330.7	4.3	5,978.5	78.6	183.0	2.4	0	0
2013	7,000.0	33.9	13,630.0	66.1	20,630.0	100	3,926.50	19	1,359.1	6.6	920.1	4.5	12,792.6	62	1,631.6	7.9	0.1	0
2014	7,000.0	52.9	6,237.6	47.1	13,237.6	100	726.3	5.5	1,439.3	10.9	2,022.5	15.3	8,896.4	67.2	126.9	1	26.3	0.2
2015	15,000.0	72.9	5,562.5	27.1	20,562.5	100	1,544.70	7.5	1,576.6	7.7	6,617.9	32.2	10,439.9	50.8	383.4	1.9	0	0
2016	30,000.0	79.4	7,795.1	20.6	37,795.1	100	437.7	1.2	805.7	2.1	16,701.2	44.2	10,485.5	27.7	9,364.2	24.8	0.8	0
2017	15,000.0	35.5	27,308.2	64.5	42,308.2	100	4,816.9	11.4	2,949.5	7	21,853.8	51.7	2,284.3	5.4	10,396.0	24.6	7.9	0
2018	16,900.0	35.5	30,663.6	64.5	47,563.6	100	12,456.1	26.2	4,756.4	10	17,494.3	36.8	190.9	0.4	12,651.3	26.6	14.7	0
2019.06	25,584.8	45.4	30,725.2	54.6	56,310.0	100	12,720.2	22.6	6,772.1	12	22,563.7	40.1	97.9	0.2	13,967.5	24.8	188.6	0.3



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

Кредит банк																	
2019.06	19,000.0	99	186.9	1	19,186.9	100	-	0	-	0	19,186.9	100	-	0	-	0	0
Үрий банк (БНСУ)																	
2012	-	0	20.5	100	20.5	100	-	0	-	0	-	0	-	0	-	0	20.5
2013	-	0	4.0	100	4.0	100	4.0	100	-	0	-	0	-	0	-	0	0
2014	-	0	7.3	100	7.3	100	7.3	100	-	0	-	0	-	0	-	0	0
2015	-	0	9.7	100	9.7	100	9.7	100	-	0	-	0	-	0	-	0	0
2016	-	0	11.0	100	11.0	100	11.0	100	-	0	-	0	-	0	-	0	0
2017	-	0	15.3	100	15.3	100	15.3	100	-	0	-	0	-	0	-	0	0
2018	-	0	7.3	100	7.3	100	7.3	100	-	0	-	0	-	0	-	0	0
2019.06	-	0	10.8	100	10.8	100	10.8	100	-	0	-	0	-	0	-	0	0
Кеб банк (БНСУ)																	
2012	-	0	5.6	100	5.6	100	-	0	-	0	-	0	-	0	-	0	5.6
2013	-	0	11.2	100	11.2	100	11.2	100	-	0	-	0	-	0	-	0	0
2014	-	0	4.5	100	4.5	100	4.5	100	-	0	-	0	-	0	-	0	0
2015	-	0	6.0	100	6.0	100	6.0	100	-	0	-	0	-	0	-	0	0
2016	-	0	10.3	100	10.3	100	10.3	100	-	0	-	0	-	0	-	0	0
2017	-	0	23.0	100	23.0	100	23.0	100	-	0	-	0	-	0	-	0	0
2018	-	0	17.2	100	17.2	100	17.2	100	-	0	-	0	-	0	-	0	0
2019.06	-	0	18.4	100	18.4	100	18.4	100	-	0	-	0	-	0	-	0	0
Күкмин банк (БНСУ)																	
2015	-	0	3.5	100	3.5	100	2.2	62	-	0	-	0	-	0	-	0	1.3
2016	-	0	8.9	100	8.9	100	2.1	24.2	-	0	-	0	-	0	-	0	6.7
2017	-	0	29.2	100	29.2	100	3.1	10.6	-	0	-	0	-	0	-	0	26.1
2018	-	0	34.7	100	34.7	100	3.3	9.5	-	0	-	0	-	0	-	0	31.4
2019.06	-	0	39.8	100	39.8	100	1.7	4.2	-	0	-	0	-	0	-	0	38.2
Шинхан банк (БНСУ)																	
2012	-	0	37.8	100	37.8	100	-	0	-	0	-	0	-	0	-	0	37.8
2013	-	0	11.2	100	11.2	100	11.2	100	-	0	-	0	-	0	-	0	0
2014	-	0	13.0	100	13	100	13.0	100	-	0	-	0	-	0	-	0	0
2015	-	0	10.3	100	10.3	100	10.3	100	-	0	-	0	-	0	-	0	0
2016	-	0	12.9	100	12.9	100	12.9	100	-	0	-	0	-	0	-	0	0



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

2017	-	0	8.4	100	8.4	100	8.4	100	-	0	-	0	-	0	-	0	-	0
2018	-	0	5.6	100	5.6	100	5.6	100	-	0	-	0	-	0	-	0	-	0
2019.06	-	0	8.6	100	8.6	100	8.6	100	-	0	-	0	-	0	-	0	-	0
Төрийн банк																		
2012	-	0	2,244.0	100	2,244.0	100	1,065.3	47.5	327.5	14.6	117.8	5.2	504.3	22.5	195.3	8.7	33.9	1.5
2013	50,000.0	26.7	137,320.0	73.3	187,320.0	100	59,848.6	31.9	8,772.4	4.7	33,637.5	18	56,969.8	30.4	26,916.7	14.4	1,175.00	0.6
2014	90,000.0	57	67,817.6	43	157,817.6	100	38,195.4	24.2	10,001.3	6.3	28,547.4	18.1	53,138.8	33.7	26,857.1	17	1,077.70	0.7
2015	45,000.0	51.6	42,133.2	48.4	87,133.2	100	20,715.7	23.8	3,207.3	3.7	11,947.6	13.7	48,002.2	55.1	1,946.9	2.2	1,313.60	1.5
2016	35,000.0	46.3	40,589.6	53.7	75,589.6	100	9,231.1	12.2	2,522.0	3.3	27,956.5	37	34,273.9	45.3	1,491.6	2	114.5	0.2
2017	25,000.0	26.6	68,953.9	73.4	93,953.9	100	17,706.7	18.8	5,096.6	5.4	27,541.9	29.3	42,249.6	45	1,181.1	1.3	178.1	0.2
2018	50,000.0	33.7	98,357.8	66.3	148,357.8	100	41,522.9	28	8,560.9	5.8	93,702.6	63.2	1,556.2	1	2,394.8	1.6	620.4	0.4
2019.06	105,050.0	59.1	72,747.8	40.9	177,797.8	100	42,872.1	24.1	6,470.2	3.6	118,472.4	66.6	6,170.9	3.5	3,297.5	1.9	514.6	0.3
Төрийн сан																		
2012	-	0	113,217.4	100	113,217.4	100	92,728.6	81.9	3,158.6	2.8	3,073.2	2.7	9,509.3	8.4	3,046.7	2.7	1,701.10	1.5
2013	-	0	244,509.6	100	244,509.6	100	116,173.9	47.5	1,317.0	0.5	29,201.3	11.9	56,027.5	22.9	39,278.9	16.1	2,510.90	1
2014	-	0	84,313.6	100	84,313.6	100	21,785.7	25.8	1,285.3	1.5	16,756.1	19.9	6,598.0	7.8	36,278.9	43	1,609.50	1.9
2015	-	0	44,958.9	100	44,958.9	100	6,851.5	15.2	711.1	1.6	16,485.7	36.7	8,465.8	18.8	8,500.0	18.9	3,944.90	8.8
2016	-	0	112,950.6	100	112,950.6	100	1,992.2	1.8	1,047.3	0.9	37,337.2	33.1	56,138.4	49.7	15,924.7	14.1	510.7	0.5
2017	-	0	104,115.1	100	104,115.1	100	2,726.5	2.6	1,535.5	1.5	37,525.8	36	45,395.3	43.6	16,632.2	16	299.8	0.3
2018	-	0	83,931.4	100	83,931.4	100	5,525.9	6.6	762.6	0.9	49,825.5	59.4	3,329.4	4	23,358.8	27.8	1,129.10	1.3
2019.06	-	0	94,887.1	100	94,887.1	100	32,953.5	34.7	688.0	0.7	27,147.1	28.6	6,278.3	6.6	22,098.4	23.3	5,721.90	6
Тээвэр хөгжлийн банк																		
2018	45,000.0	97.1	1,327.5	2.9	46,327.5	100	-	0	-	0	42,196.7	91.1	-	0	4,130.8	8.9	-	0
2019.06	45,000.0	97.7	1,061.9	2.3	46,061.9	100	-	0	-	0	41,959.3	91.1	-	0	4,102.7	8.9	-	0
Улаанбаатар хотын банк																		
2012	20,000.0	52.2	18,292.0	47.8	38,292.0	100	507.5	1.3	1.2	0	24.4	0.1	17,749.6	46.4	18,468.9	48.2	1,540.40	4
2013	30,000.0	53	26,554.8	47	56,554.8	100	10,400.6	18.4	527.2	0.9	4,714.6	8.3	24,752.5	43.8	15,570.7	27.5	589.2	1
2014	155,000.0	87	23,225.9	13	178,225.9	100	64,814.9	36.4	11.3	0	30,747.5	17.3	64,863.2	36.4	17,425.5	9.8	363.6	0.2
2015	113,000.0	91.1	11,037.0	8.9	124,037.0	100	3,547.4	2.9	18.2	0	42,199.5	34	50,604.1	40.8	27,632.3	22.3	35.5	0
2016	159,000.0	93.4	11,242.3	6.6	170,242.3	100	2,103.6	1.2	472.7	0.3	53,686.4	31.5	65,057.2	38.2	48,220.4	28.3	702	0.4
2017	159,000.0	86.5	24,872.6	13.5	183,872.6	100	3,794.2	2.1	1,501.1	0.8	56,523.2	30.7	69,977.9	38.1	52,011.9	28.3	64.2	0
2018	68,355.0	79.7	17,407.8	20.3	85,762.8	100	7,965.8	9.3	5,378.6	6.3	23,469.2	27.4	205.1	0.2	48,064.5	56	679.5	0.8



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

2019.06	99,652.6	82.3	21,485.3	17.7	121,137.8	100	12,100.4	10	6,766.6	5.6	49,805.9	41.1	3,129.9	2.6	49,270.3	40.7	64.8	0.1
Үндэсний хөрөнгө оруулалтын банк																		
2013	-	0	5,069.8	100	5,069.8	100	5,069.8	100	-	0	-	0	-	0	-	0	-	0
2014	15,000.0	98.7	193.6	1.3	15,193.6	100	15,193.6	100	-	0	-	0	-	0	-	0	-	0
2015	15,000.0	95.6	687.8	4.4	15,687.8	100	27.3	0.2	-	0	10,511.9	67	5.1	0	5,143.6	32.8	-	0
2016	35,000.0	97.3	957.3	2.7	35,957.3	100	0.1	0	4.1	0	27,110.7	75.4	3,457.1	9.6	5,385.3	15	-	0
2017	25,000.0	43.7	32,207.9	56.3	57,207.9	100	313.3	0.5	9.7	0	30,044.6	52.5	21,666.6	37.9	5,173.6	9	0	0
2018	31,830.0	95.5	1,505.2	4.5	33,335.2	100	388.6	1.2	12.8	0	27,508.9	82.5	0.1	0	5,424.7	16.3	0	0
2019.06	5,035.6	46.1	5,898.4	53.9	10,934.0	100	31.8	0.3	5.1	0	5,831.3	53.3	0	0	5,060.2	46.3	5.6	0.1
ХААН банк																		
2012	8,000.0	21.1	29,979.0	78.9	37,979.0	100	21,210.7	55.8	678.4	1.8	2,371.9	6.2	4,233.2	11.1	8,953.9	23.6	530.9	1.4
2013	15,000.0	15	84,787.2	85	99,787.2	100	63,652.7	63.8	2,198.2	2.2	16,854.0	16.9	13,455.7	13.5	1,624.8	1.6	2,001.7	2
2014	12,000.0	20.3	47,156.6	79.7	59,156.6	100	40,515.3	68.5	1,932.1	3.3	10,816.4	18.3	4,577.5	7.7	423.1	0.7	892.2	1.5
2015	6,000.0	13.1	39,918.0	86.9	45,918.0	100	21,415.7	46.6	1,467.0	3.2	11,513.7	25.1	5,806.4	12.6	5,623.5	12.2	91.7	0.2
2016	6,000.0	19	25,642.1	81	31,642.1	100	9,717.7	30.7	973.4	3.1	12,847.5	40.6	5,349.6	16.9	1,561.0	4.9	1,192.9	3.8
2017	18,000.0	27.4	47,600.3	72.6	65,600.3	100	22,264.5	33.9	1,379.5	2.1	36,696.9	55.9	3,416.9	5.2	958.8	1.5	883.7	1.3
2018	54,000.0	39.3	83,419.7	60.7	137,419.7	100	48,875.9	35.6	5,187.7	3.8	77,816.6	56.6	3,169.4	2.3	1,236.3	0.9	1,133.9	0.8
2019.06	121,604.0	53.1	107,421.7	46.9	229,025.7	100	65,613.3	28.6	14,070.7	6.1	138,154.0	60.3	5,148.7	2.2	4,076.2	1.8	1,962.8	0.9
Хадгаламж банк																		
2012	40,000.0	42.5	54,012.2	57.5	94,012.2	100	44,294.3	47.1	1,362.5	1.4	14,106.60	15	18,222.2	19.4	15,800.2	16.8	226.4	0.2
Хас банк																		
2012	-	0	297.4	100	297.4	100	144.9	48.7	11.5	3.9	35.1	11.8	88.5	29.8	11.4	3.8	6.0	2
2013	-	0	596.3	100	596.3	100	354.7	59.5	5.7	1.0	61.3	10.3	155.2	26	15.3	2.6	4.1	0.7
2014	-	0	918.6	100	918.6	100	257.3	28	9.8	1.1	13	1.4	411.4	44.8	58.1	6.3	168.9	18.4
2015	-	0	845.5	100	845.5	100	190.1	22.5	3.1	0.4	43.4	5.1	517.7	61.2	32.0	3.8	59.1	7
2016	-	0	468.3	100	468.3	100	96.1	20.5	27.9	6.0	13	2.8	202.2	43.2	61.4	13.1	67.8	14.5
2017	-	0	1,809.7	100	1,809.7	100	266.5	14.7	58.7	3.2	53.6	3	1,308.5	72.3	92.7	5.1	29.7	1.6
2018	-	0	1,510.8	100	1,510.8	100	467.9	31	498.9	33.0	121	8	89.2	5.9	225.7	14.9	108.1	7.2
2019.06	-	0	3,478.0	100	3,478.0	100	969.9	27.9	1,403.7	40.4	224.5	6.5	426.3	12.3	250.4	7.2	203.1	5.8
Худалдаа хөгжлийн банк																		
2012	20,000.0	62.5	11,992.2	37.5	31,992.2	100	9,599.7	30	184.4	0.6	9,816.9	30.7	8,383.0	26.2	3,223.5	10.1	784.7	2.5
2013	-	0	19,799.3	100	19,799.3	100	10,007.1	50.5	302.9	1.5	2,275.7	11.5	5,465.9	27.6	147.6	0.7	1,600.0	8.1



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

2014	-	0	7,367.8	100	7,367.8	100	2,837.6	38.5	198.9	2.7	2,392.9	32.5	599.6	8.1	850.8	11.5	488.0	6.6
2015	-	0	7,692.4	100	7,692.4	100	5,753.2	74.8	243.4	3.2	849.4	11	476.2	6.2	8.9	0.1	361.2	4.7
2016	40,000.0	78.8	10,760.8	21.2	50,760.8	100	5,051.8	10	24.5	0	41,206.1	81.2	965.2	1.9	605.2	1.2	2,908.1	5.7
2017	71,000.0	89.1	8,642.2	10.9	79,642.2	100	3,981.2	5	362.5	0.5	55,951.1	70.3	18,752.8	23.5	155.2	0.2	439.5	0.6
2018	150.0	0.7	22,183.7	99.3	22,333.7	100	16,755.4	75	2,604.9	11.7	1,164.0	5.2	1,320.9	5.9	152.8	0.7	335.7	1.5
2019.06	324	0.8	40,344.4	99.2	40,668.4	100	35,948.5	88.4	1,093.3	2.7	1,132.0	2.8	1,768.9	4.3	157.9	0.4	567.8	1.4
Чингис хаан банк																		
2012	13,000.0	99.3	97.3	0.7	13,097.3	100	-	0	-	0	13,097.3	100	-	0	-	0	-	0
2013	18,000.0	74.1	6,295.1	25.9	24,295.1	100	1,501.2	6.2	-	0	19,928.3	82	2,199.8	9.1	665.8	2.7	-	0
2014	43,000.0	79.3	11,205.6	20.7	54,205.6	100	1,789.7	3.3	-	0	43,889.5	81	7,823.0	14.4	703.4	1.3	-	0
2015	48,000.0	75.4	15,624.0	24.6	63,624.0	100	199.8	0.3	-	0	50,132.9	78.8	11,428.8	18	1,862.5	2.9	-	0
2016	48,000.0	79.8	12,152.6	20.2	60,152.6	100	479.3	0.8	360.3	0.6	46,429.7	77.2	11,283.4	18.8	1,600.0	2.7	-	0
2017	77,590.0	61.7	48,246.9	38.3	125,836.9	100	279.7	0.2	380.6	0.3	78,033.2	62	43,051.9	34.2	4,091.4	3.3	0.1	0
2018	70,120.0	72.6	26,423.4	27.4	96,543.4	100	272.0	0.3	402.1	0.4	91,444.8	94.7	1.7	0	4,422.8	4.6	0.1	0
2019.06	70,130.0	76.9	21,050.3	23.1	91,180.3	100	12,818.5	14.1	2,144.8	2.4	74,656.5	81.9	5.0	0	1,548.2	1.7	7.3	0
2012 ОНЫ НИЙТ ДҮН	163,000.0	39.6	248,662.5	60.4	411,662.5	100	180,629.1	43.9	6,794.7	1.7	57,018.4	13.9	103,651.8	25.2	58,259.3	14.2	5,309.2	1.3
2013 ОНЫ НИЙТ ДҮН	245,000.0	30	571,127.5	70	816,127.5	100	295,483.0	36.2	15,296.4	1.9	140,440.0	17.2	250,224.3	30.7	106,076.7	13	8,607.1	1.1
2014 ОНЫ НИЙТ ДҮН	532,000.0	65.8	277,105.5	34.2	809,105.5	100	231,466.0	28.6	17,823.8	2.2	172,663.6	21.3	269,333.1	33.3	112,384.3	13.9	5,434.7	0.7
2015 ОНЫ НИЙТ ДҮН	467,000.0	66.7	232,910.6	33.3	699,910.6	100	81,135.0	11.6	11,775.9	1.7	217,722.1	31.1	297,964.7	42.6	85,041.7	12.2	6,271.0	0.9
2016 ОНЫ НИЙТ ДҮН	583,000.0	66.8	289,603.9	33.2	872,603.9	100	34,185.0	3.9	8,064.0	0.9	338,493.1	38.8	367,787.8	42.1	117,670.9	13.5	6,403.0	0.7
2017 ОНЫ НИЙТ ДҮН	450,590.0	41.1	646,426.4	58.9	1,097,016.4	100	65,318.5	6	16,818.8	1.5	442,024.0	40.3	444,434.8	40.5	126,390.3	11.5	2,030.1	0.2
2018 ОНЫ НИЙТ ДҮН	439,335.0	46.3	508,617.1	53.7	947,952.1	100	149,128.9	15.7	32,795.9	3.5	608,576.8	64.2	11,267.0	1.2	142,019.9	15	4,163.8	0.4
2019 ОНЫ 6 ДУГААР САРЫН НИЙТ ДҮН	592,207.5	56.8	449,948.7	43.2	1,042,156.2	100	241,974.1	23.2	42,568.2	4.1	618,717.5	59.4	25,164.1	2.4	104,270.9	10	9,461.5	0.9

**Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулсан хадгаламжийн хүүг Монголбанкны бодлогын хүүтэй харьцуулсан судалгаа**

2012 он					
Банкны нэр	Гэрээний дүн /тэрбум төгрөг	Хугацаа (сар)	Хадгаламжийн дундаж хүү /хувь/	Монголбанкны бодлогын хүү /хувь/	Хүүгийн зөрүү (+илүү, -дутуу)
Голомт банк	36.0	12	11.80	13.25	(1.45)
Капитал банк	26.0	12	11.60	13.25	(1.65)
УБ хотын банк	20.0	12	11.66	13.25	(1.59)
Хаан банк	8.0	12	15.00	13.25	1.75
Хадгаламж банк	40.0	12	11.80	13.25	(1.45)
Худалдаа хөгжлийн банк	20.0	12	11.60	13.25	(1.65)
Чингис хаан банк	13.0	12	13.20	13.27	(0.07)
2012 оны нийт дүн	163.0				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	155.0				
2013 он					
Голомт банк	20.0	12	11.80	10.50	1.30
Капитал банк	105.0	12	11.65	10.90	0.75
Капитрон банк	7.0	12	11.20	11.50	(0.30)
Төрийн банк	30.0	12	11.60	10.83	0.77
УБ хотын банк	30.0	12	11.60	10.83	0.77
Хаан банк	15.0	12	11.50	11.50	-
Хадгаламж банк	20.0	12	11.00	11.50	(0.50)
Чингис хаан банк	18.0	12	11.63	10.78	0.86
2013 оны нийт дүн	245.0				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	27.0				
2014 он					
Голомт банк	20.0	12	10.50	12.00	(1.50)
Капитал банк	190.0	12	10.50	11.21	(0.71)
Капитрон банк	7.0	12	10.50	10.50	-
Төрийн банк	90.0	12	11.08	11.17	(0.09)
УБ хотын банк	155.0	12	10.50	11.08	(0.58)
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	15.0	12	10.50	10.50	-
Хаан банк	12.0	12	10.50	10.50	-
Чингис хаан банк	43.0	12	10.50	10.95	(0.45)
2014 оны нийт дүн	532.0				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	498.0				
2015 он					
Голомт банк	40.0	24	11.80	13.00	(1.20)
Капитал банк	205.0	24	11.44	12.73	(1.28)
Капитрон банк	20.0	24	11.80	13.00	(1.20)
Төрийн банк	45.0	24	11.22	12.56	(1.33)
УБ хотын банк	113.0	24	11.80	13.00	(1.20)
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	15.0	12	11.80	13.00	(1.20)
Хаан банк	6.0	12	11.80	13.00	(1.20)
Чингис хаан банк	48.0	24	11.80	13.00	(1.20)



Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

2015 оны нийт дүн	492.0				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	492.0				
2016 он					
Голомт банк	50.0	5.6	9.00	10.50	(1.50)
Капитал банк	180.0	12.5	9.30	12.04	(2.74)
Капитрон банк	30.0	3.5	9.00	10.50	(1.50)
Төрийн банк	71.0	10.6	9.58	10.71	(1.13)
УБ хотын банк	133.0	7	9.00	10.69	(1.69)
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	35.0	5.9	9.17	10.50	(1.33)
Хаан банк	6.0	11	9.50	12.00	(2.50)
Худалдаа хөгжлийн банк	40.0	7	9.00	10.50	(1.50)
Чингис хаан банк	48.0	11	9.60	12.00	(2.40)
2016 оны нийт дүн	593.0				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	593.0				
2017 он					
Голомт банк	40.0	12.0	15.15	14.00	1.15
Капитал банк	99.0	5.4	15.12	12.00	3.12
Капитрон банк	15.0	12.0	15.00	12.00	3.00
Төрийн банк	35.0	5.6	10.60	14.00	(3.40)
УБ хотын банк	159.0	11.1	15.07	12.50	2.57
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	25.0	12.0	15.26	13.60	1.66
Хаан банк	18.0	10.0	11.00	14.00	(3.00)
Чингис хаан банк	82.6	11.2	15.23	12.90	2.34
Худалдаа хөгжлийн банк	71.0	12.0	15.25	12.00	3.25
2017 оны нийт дүн	544.6				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	53.0				
2018 он					
Голомт банк	110.6	11.3	13.19	10.09	3.09
Капитал банк	81.4	9.1	15.02	10.03	4.99
Капитрон банк	16.9	12.0	12.99	11.00	1.99
Төрийн банк	50.0	12.0	12.90	10.20	2.70
УБ хотын банк	126.3	10.4	13.96	10.46	3.50
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	34.3	11.5	14.77	10.85	3.91
Хаан банк	54.0	12.0	12.70	10.26	2.44
Чингис хаан банк	78.1	11.6	13.97	10.64	3.33
Худалдаа хөгжлийн банк	15.2	7.5	14.99	10.99	3.99
Тээвэр хөгжлийн банк	45.0	12.0	13.50	10.00	3.50
2018 оны нийт дүн	611.8				
Үүнээс бодлогын хүүгээс доогуур хадгалуулсан	0.0				

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

